

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7 - 47

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

7 - 47

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 24-ний өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 10 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Д.Батлут, Ж.Баясгалан, Г.Дамдинням, Б.Мөнхсоёл;  
Чөлөөтэй: Х.Булгантуяа, Х.Ганхуяа;  
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа;

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Ө.Ариунболор, Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхжин, Ч.Мөнхшүр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Гадаад хэргийн сайд Б.Батцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, З.Мэндсайхан, Да.Цогтбаатар, Ж.Батжаргал, Б.Заяабал, Б.Түвшин, Ж.Ганбаатар, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж,

Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Б.Энхбаяр, Ж.Баярмаа нар үг хэлэв.

**Ц.Даваасүрэн:** 1.Үндэсний байгалийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 13  
Бүгд: 17  
23.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**5.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**6.**“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

---

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

*Хуралдаан 16 цаг 00 минутад түр завсарлаж, 17 цаг 50 минутаас үргэлжлэв.*

Улсын Их Хурлын гишүүн Б.Батцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 2  
Бүгд: 13  
84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** 7. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 2

---

Бүгд: 13  
84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 2  
Бүгд: 13  
84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 17 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 57 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 57 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордны “Их засаг” танхим  
14 цаг 10 минут

### ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Даваасүрэн:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдааны ирц 64 хувьтай байна. Хангалттай байна.

Өнөөдрийн хуралдааныг эхлүүлье.  
/алх цохвив/

Ирсэн гишүүдээ танилцуулчихъя. Миний бие, Норовын Алтанхуяг гишүүн, Далайн Батбаяр гишүүн ирсэн байна, Ринчиндоржийн Батболд гишүүн бүртгүүлсэн байна, Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна, Батмөнхийн Батцэцэг гишүүн ирсэн байна, Жамбалын Ганбаатар гишүүн ирсэн байна, Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна, Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна, Батжаргалын Заяабал гишүүн ирсэн байна, Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн ирсэн байна, Загджавын Мэндсайхан гишүүн ирсэн байна, Даваахүүгийн Пүрэвдаваа

гишүүн ирсэн байна, Банзрагчийн Түвшин гишүүн ирсэн байна, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн ирсэн байна, Даваагийн Цогтбаатар гишүүн ирсэн байна, Тогтохын Чойжилсүрэн гишүүн нар ирсэн байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя. Нэг асуудал байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг өнөөдөр хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад байгаа юу? Байхгүй байна. /алх цохив/

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн нийт 5 хууль, 3 тогтоолын

төслүүд буюу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах



тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Засгийн газраас үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Тогтоолын хавсралт нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэж эхэллэ.

Өнөөдрийн хуралдаанд ажлын хэсгийн оролцох гишүүдийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн

дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Солонгийн Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Өлзийсайханы Ариунболор Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, Батсуурийн Энхжин Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Чимэдийн Мөнхшүр Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн гэсэн хүмүүс оролцож байна.

Зарим байхгүй байгаа хүмүүс байвал ажлын хэсгийн хүмүүсээ дуудаарай.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн танилцуулгыг Б.Батцэцэг сайд хийх юм уу? Б.Батцэцэг сайд хийе. Б.Батцэцэг сайд.

**Б.Батцэцэг:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт 5 хуулийн төсөл, 3 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Хууль тогтоомжийн төслүүдийн талаар товч дурдвал:

**1.Хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, төсөв хооронд үе шаттай, оновчтой зохицуулалт хийх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж**

мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулийн төсөл.

**2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олон нийтийн болон хараат бус хөндлөнгийн хяналтыг өргөжүүлж, сахилга бат, хариуцлагыг сайжруулж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.**

**3.Бүсчилсэн хөгжлийг үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулах үйлдвэрүүдийг татварын бодлогоор дэмжих зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Бүс төсвийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх төслийг дэмжих зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.**

**4.Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, жишиг хүүг тогтоох, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.**

**5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.**

**6.Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах, байгаль,**

цаг уурын болон бусад болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсрууллаа.

Хууль тогтоомжийн төслүүд батлагдсанаар бүсчилсэн хөгжлийг дэмжиж, хамтарсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөгжлийг хурдасгах хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд цаг алдалгүй шуурхай, үр дүнтэй хэрэгжих боломж бүрдэх юм.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Б.Батцэцэг сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Ж.Ганбаатар гишүүнээр тасаллаа. Г.Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** Дагасан хуулиудтай холбогдуулаад орж ирж байгаа асуудал дээр нэг анхаарал татаж байгаа нэг зүйл байна.

Тогтоолын төсөл орж ирсэн. Бонд гаргахтай холбоотойгоор.

Тэгээд би энэ дээр тодруулж асуух гээд байгаа зүйл нь яг энэ бондуудыг гаргаж байгаа асуудал чинь Засгийн газар дээр ямар нэг байдлаар хэмжээгүйгээр,

хязгааргүйгээр бонд гаргах эрх авч байгаа асуудал чинь зарчмын хувьд зөв юм уу? Яагаад тоо хэмжээг нь дурдаж оруулж ирээгүй юм бэ?

Энэ бонд гаргаж байгаа гол зориулалт нь өөрөө юу юм бэ? Тайлбар дээр нь “**Номад бонд**”-ын **580 сая ам.доллар**-ыг дахиад “refinance” буюу “дахин санхүүжүүлэх” асуудлаар Засгийн газар үнэт цаасаар бонд гаргах энэ тогтоолын төслийг оруулж ирж байгаа гэж бичсэн байна.

Гэтэл “Номад бонд”-ын чинь эргэн төлөлт чинь 2025 онд байхгүй шүү дээ.

Тэгэхээр 2026 онд хийгдэх ёстой энэ бондыг дахин санхүүжилт хийх ч гэдэг юм уу, энэ ямар шаардлага байгаад байгаа юм бэ?

Яагаад “Номад бонд” гэж танилцуулга бэлдээд, тэгээд дахин санхүүжилт хийх эрх авах гэж байгаа юм шиг байдлаар орж ирж байгаа нь зүгээр төсвийн алдагдлыг нөхөх гэж байгаа ийм хувилбар юм биш үү гэж бодоод байгаа юм.

Ер нь 2 их наядын төсвийн алдагдал бий болох гэж байгаа. Төсвийнхөө алдагдлыг яг яаж нөхөх гэж байгаа юм?

Төсвийн танилцуулга дээр бичсэнээр бараг 300 тэрбумынх байсан уу. Төсвийн алдагдлыг нөхөх. Өөр эх үүсвэрүүд бараг байхгүй шахуу байгаа.

Тэгэхээр ер нь төсвийнхөө алдагдлыг яаж нөхөх, ямар зохицуулалт хийх, ямар юу байгаад байгаа юм?

Тэгээд би зарчмын хувьд хэрэв энэ хэмжээ хязгааргүйгээр тогтоолгох юм бол үүнийг зарчмын хувьд дэмжихгүй.

Хэрвээ зүгээр магадгүй ажлын хэсэг болоод Төсвийн байнгын хороон дээрээс хоёр дахь хэлэлцүүлгийн явцад хэмжээ хязгаарыг нь зааж өгөх асуудал байх юм бол тэрийг нь тов тодорхойгоор бичээд оруулж ирж болно л гэсэн нэг ийм асуудал байгаа юм.

Энэ дээр хариу тайлбар аваадахъя.

**Ц.Даваасүрэн:** Хэн хариулах вэ? Ж.Ганбат дарга хариулах уу? Ж.Ганбат аа. Хэн хариулах юм? 3 номер.

**Л.Гантогтох:** Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох. Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариульъя.

Улсын Их Хурлын тогтоол орсноор хэмжээ хязгааргүйгээр Засгийн газрын үнэт цаас гаргах эрх өгч байгаа зүйл биш.

Энэ хязгаар маань өөрөө 2025 оны Төсвийн тухай хуулиараа хязгаарлагдаж өгнө.

Дотоод үнэт цаас бол 2025 оны төсвийн тухай хуулийн 11.1 дээр ирэх онд дээд хэмжээ нь **300 тэрбум** хүртэлх дотоод үнэт цаас арилжаална гээд заагаад өгчихсөн байгаа.

Гадаад үнэт цаас бол 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл дээр зөвхөн дахин санхүүжилтийн зорилгоор Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегид нийцүүлэн арилжаалж болно гэсэн ийм хоёр хязгаар зааж өгч байгаа.

Улсын Их Хурлаар батлагдсан Засгийн газрын Өрийн удирдлагын дунд хугацааны стратеги дээр болохоор 2023-2025 оны хооронд Засгийн газар зөвхөн дахин санхүүжилтийн зорилгоор арилжааны нөхцөлтэй зээлийг хийх буюу Засгийн газрын гадаад үнэт цаас гаргана гэж зааж өгсөн.

2025 он дээр яагаад зааж тавьж өгч байгаа вэ гэхээр 2026 оноос эхлээд бид дахин арилжааны нөхцөлтэй гадаад бонд буюу 2026, 2027, 2028 он дээр ийм төлөх нөхцөлтэй байгаа.

Гэхдээ “Номад бонд” маань 2026 оны 4 дүгээр сар буюу эхний хагаст төлөгдөх ийм нөхцөлтэй.

Тэгэхээр 2025 он дээр бид гадаад зах зээлээ харж байгаад хэрвээ хүү багатай, таатай, дахин санхүүжилтийн эерэг нөхцөл бүрдсэн ийм нөхцөлд дахин санхүүжилтийн арга хэмжээг авч хэрэгжүүлж болно гэдэг ийм л эрх авч байгаа зүйл.

Тэгээд дотоод үнэт цаас дээр бол яг Төсвийн тухай хуулиараа хязгаараа тогтоож өгч байгаа.

**Ц.Даваасүрэн:** Чи нөгөө эх үүсвэр талд бичсэнийг хэлээд байна уу?

Эх үүсвэр талд биччихсэн байгаагаа хэлээд байх шиг байна тийм үү?

**Л.Гантогтох:** Тийм. 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл дээр 11.1 дээр нь “гаргах дотоод үнэт цаасны дээд хэмжээ” гэж ойлгож байгаа.

**Ц.Даваасүрэн:** Жагсаалт дотроо Та нар ингээд алдагдал, алдагдлын доор эх үүсвэр гээд биччихсэн байгаа шүү дээ.

**Л.Гантогтох:** Тийм.

**Ц.Даваасүрэн:** Тэр дотроо одоо жишээлбэл гадаад эх үүсвэр, дотоод эх үүсвэр гээд бондууд тэд тэд гээд бичсэн. Тэрийгээ хэлээд байна уу?

**Л.Гантогтох:** Тийм. Гадаад бондоор төсвийн алдагдал санхүүжүүлж болохгүй.

**Ц.Даваасүрэн:** Тэрийгээ тэгвэл нэгэнт тийм байгаа юм бол мөнгөн дүнгээр нь тавьчихад яагаад байгаа юм л гээд байгаа юм байна шүү дээ.

Өөрчлөлт оруулаад, гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаад наад байгаа мөнгөн дүнгээр чинь өөрчилчихвөл болох юм уу?

**Л.Гантогтох:** Их Хурлын тогтоолын төсөл орж байгаа нь Өрийн удирдлагын тухай хуулийн 26.3 дугаар хэсэг дээр Засгийн газрын гадаад, дотоодын үнэт цаас гаргах аливаа шийдвэрийн төслийг Засгийн газарт Улсын Их Хурал, Засгийн газар оруулна гэсэн ийм заалтын дагуу оруулж байгаа.

Яг энэ мөнгөн дүнгээр хязгаар тогтоож байгаа нь өөрөө Төсвийн тухай хуулиараа тухайн төсвийн жилийн хэлэлцүүлгийн...

**Ц.Даваасүрэн:** Тийм тийм. Тэгэхээр тэр мөнгөн дүнг чинь Та нар ингээд тогтоочихсон гэж хариулаад байгаа учраас тэр мөнгөн дүнгээр чинь бид одоо энэ өргөн барьсан хуульд чинь өөрчлөлт оруулаад явчихъя гээд байна шүү дээ.

**Ж.Ганбат:** Бид ер нь төсөв өргөн барихдаа санхүүжүүлэх эх үүсвэрийг юунаас юм бэ гэдгээ бид тусгаж өгч оруулдаг.

Тэгэхээр бид өөрөөр хэлэх юм бол 2025 оны төсвийн хууль дээрээ **300 тэрбум** төгрөгийг бид дотоод бондоор гэдэг байдлаар тусгачихсан байгаа.

Нийт тэнцвэржүүлсэн алдагдал дээр 1.9 их наяд төгрөгийг бид гадаад зээлийн ашиглалтаар нөхнө гээд тооцож байгаа.

Тэгэхээр суурь тэнцлийн ашгаараа гадаад зээлийн үндсэн төлбөрийг төлөх хуулийн ийм заалттай ингэж зохицуулчихсан байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл Г.Тэмүүлэн гишүүний санал гаргаад тэр эх үүсвэр талд байж байгаа хэмжээнүүдийг нь тавиад явал болчих л юм шиг байна шүү дээ. Тийм ээ. Тодотгоё. Г.Тэмүүлэн гишүүний микрофоныг.

**Г.Тэмүүлэн:** Тэгэхээр саяын тэр дотоод бонд гаргах, гадаад бонд гаргах дээр яг мөнгөн дүнгүүд нь тТа хэд тодорхой тавьсан зүйл байгаа юу? Яг ирэх жил ер нь гадаад бонд шинээр хэдийг гаргах юм? Дотоод бонд ирэх жил яг шинээр хэдийг гаргах юм?

Хэрэв үнэхээр яг мөнгөн дүн юунууд нь байгаа бол тэр мөнгөн дүнгээр нь хязгаарыг нь тавьж өгөөд л, тогтоол дээр нь тусгаж өгөөд л явахад зарчмын хувьд нэг их.

**Ц.Даваасүрэн:** Байгаа гээд байна шүү дээ. Тэр нөгөө эх үүсвэр талд

байгаа хэмжээнүүдийг хэлээд байна шүү дээ.

Ж.Ганбат.

**Ж.Ганбат:** Дотоод бондын дээд хэмжээ 300 тэрбум төгрөгийг дотоодын үнэт цаас гаргана гээд хууль дээр туссан. Гадаад бонд дээр бид яах вэ дахин санхүүжилт хийнэ гээд саяын бид нарын тайлбарласнаар үнэхээр зах зээл дээр бид ашигтай байдал үүсэх юм бол дахин санхүүжилт хийгээд явах учраас яах вэ, одоо боломжууд гарвал гэдэг байдлаар л эрхээ авч байгаа байхгүй юу.

**Ц.Даваасүрэн:** Та нар тэр эх үүсвэр талд гадаад бонд шинээр арилжих нь 1.4 их наяд гэсэн юм байна. Тийм ээ. Тийм байна. Тийм үү?

Үндсэн төлбөрт бол яах вэ 243-ыг үндсэн төлбөрт төлнө. Шинээр гаргах нь 1.4 их наяд гэсэн байна. Үүгээр нь тавьчихаж болох юм уу?

**С.Тулга:** Сайн байна уу? Гишүүний асуултад тодруулга өгье.

Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга.

Энэ 2025 оны төсвийн тухай хууль дээр одоо тоо тавьчихсан байгаа нь зөвхөн дотоод бонд. Дээд хэмжээ 300 тэрбум гээд.

Засгийн газрын гадаад үнэт цаас гарах нь зөвхөн дахин санхүүжүүлэх. Эх үүсвэр тал дээр байхгүй.

Ц.Даваасүрэн даргын уншиж байгаа бол нийслэлийн гаргах үнэт цаасны эх үүсвэр байгаа. Засгийн газрын бонд биш.

Нийслэлийн гадаад бондын эх үүсвэр.

**Ц.Даваасүрэн:** Эх үүсвэр нөхөхийг нь би хэлээд байгаа юм. Эх үүсвэр нь өгөх юм. Төсвийн алдагдлын доор байгаа эх үүсвэрийг яриад байгаа юм, би.

Та нар энэ дээр болохоор ингэсэн байна. Тэр эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн дотор чинь тэр гадаад зээлүүд нь дээрээ байж байгаа шүү дээ. Зарлага талдаа. Доороо. Тэнцлийн доор.

Засгийн газрын үнэт цаас дотоод, шинээр гаргах **480 тэрбум**. Гадаад **1.4 их наяд** л гэж байна шүү дээ.

**С.Тулга:** Нийслэлийн бонд.

**Ц.Даваасүрэн:** Г.Тэмүүлэн гишүүн хэлээд байгаа нь энэ дүнгээр чинь тавьчихаж болох юм уу гээд байна шүү дээ. Одоо ингээд та нар болохоор тоо тавихгүй орж ирлээ.

Тэгэхээр гадаад зээлээ. Яах вэ, та нар тогтвортой байдлын хязгаарууд байна. Мөн төсвийн хүрээний мэдэгдлээр өрийн мэдээж хязгаарууд байгаа л даа. Гэлээ гэхдээ жилийн хэмжээнд чинь хязгаар тавьчихъя гээд байна шүү дээ. Тэрийг нь болохгүй, үгүйгээ л та хэдэд хэлчихмээр байгаа юм.

**Э.Батмөнх:** Сайн байна уу? Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх.

2025 онд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл **1.9 их наядын** алдагдалтай байгаа. Энэ алдагдлыг санхүүжүүлэхээр Засгийн газрын үнэт цаас **1.5 их наяд** байгаа.

Үүний дотоод шинээр гаргах нь **490**, гадаад шинээр гаргах нь **1.4 их наяд** байгаа.

Гадаад шинээр гаргах **1.4 их наяд** нь өөрөө нийслэлийн гаднаас авах бондын эх үүсвэр байгаа.

Дотоод нь болохоор нийслэл дээр **190 тэрбум** байгаа. Улсын төсөв дээр **300 тэрбум** байгаа.

Энэ 1.9 чинь өөрөө нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл.

**Ц.Даваасүрэн:** Тийм байна. Улсын төсвийг чинь би хараадахъя.

Та нар одоо ёстой бүр нэг харааны шил зүүмээр юм өгөх юм. Улсын төсвийнх нь хаана байна.

Харин энэ бондуудын чинь энэ тавьчихсан дүнгүүдийг нь энэ дээр тогтоол дээр чинь тавиад өгчихвөл болох уу л гээд байгаа юм байна шүү дээ.

Тавиад өгчихье л гээд байна шүү дээ. Тэгвэл болох л юм байна шүү дээ.

Ж.Ганбат.

**Ж.Ганбат:** Яах вэ, бид дотооддоо гаргах 300-гийнхаа хэмжээг тавьчихсан.

Зах зээл хэрвээ 2025 онд бас урьдчилж бид нарын таашгүйгээр байх юм бол тэрийг бид 2026 оны юмыг наана нь хэрэгжвэл зүгээр л яг тоотой авах уу, үгүй юу.

Нэг тоо тавиад явчихвал дараа нь бид аль ч тохиолдолд хэрэгжүүлж л таарна шүү дээ.



Яах вэ, бид аль болох л зардал багатай, бас таатай нөхцөлийг л хүлээж л энэ дээрээ маневр хийх боломжоо л авч байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Г.Тэмүүлэн гишүүн тодруулчихъя.

**Г.Тэмүүлэн:** Би Та хэдийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн тоог чинь харчихаад л уг нь асуугаад байгаа юм л даа.

Гадаад бондоороо та хэд ирэх жил 1.4, дотоод бондоороо 490 гаргана гээд. Нийт дүнгээрээ төсвийнхөө алдагдлыг буюу 1.9 их наядыг бондоор санхүүжүүлэх, алдагдлаа нөхөх зорилгоор л бонд гаргах гээд байна гэдэг чинь эндээс уншигдаад уншигдаад байгаа байхгүй юу.

Гэтэл та хэд бичсэн танилцуулга дээр болохоор дээр болохоор зөвхөн дээр хаа хамаагүй “**Номад бонд**”-той хольж тавиад, яг үндсэн одоо юу гэдэг юм бид энэ төсвийнхөө алдагдлыг нөхөх гэж бонд гаргаад байгаа юм гэдэг танилцуулгаа ерөөсөө бичихгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгээд бодит үнэн чинь алдагдал нөхөх гэж бонд гаргаад байгаа бол тэрийгээ үнэнээр нь хэлчхээч ээ. Тэгээд тэр тоон дүнг чинь энэ тогтоол дээр нь тавиад өгье, хязгаарлаад өгье. Бид чинь хууртагдсаар байгаад хаширчхаад байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь одоо нэг талдаа бид бас хамаагүй ингэж өр зээлийг дураар нь хэмжээ хязгааргүй гаргаад байж болохгүй л байхгүй юу.

**Ц.Даваасүрэн:** Ингээд та нар нэгдсэн төсөв дээр 1.4-ийг нийслэлийн

гаргах бонд гээд. Улсын төсөв дээрээ гадаад дээр бонд гаргах байхгүй юм байна шүү дээ.

Тэгсэн мөртлөө та нар зээлээ санхүүжүүлэхээр бонд гаргана гээд байгаа шүү дээ. Тэгээд тэр чинь тэр 1.4-өөс бас гадна гаргах тухай асуудал шүү дээ.

Тийм учраас яг нийтдээ хэдийг гаргах гээд байгаа юм бэ гэдэг юмаа тодорхой хэлж өгөх хэрэгтэй байна. 3 номерын микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Г.Тэмүүлэн даргын асуултад хариулъя.

Сая Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр ямар юм хийсэн бэ гэхээр “эх үүсвэртэй зардлууд”, “эх үүсвэргүй зардлуудаа” ялгаад гаргачихсан.

Эх үүсвэртэй зардлуудаа бид “суурь тэнцэл” гэдэг дээрээ оруулаад, суурь тэнцэл дээрээ 2 хувийн ашиг хийгээд, үүгээрээ үндсэн төлбөрөө төлнө гэдэг зээл юм.

Нөгөө талдаа энэ “тэнцвэржүүлсэн тэнцэл” дээр алдагдал санхүүжүүлэхээр гэж таны хэлж байгаа яг энэ хэсэг өөрөө гадаадын зээл, тусламжаар тохирчихсон төсөл, хөтөлбөрүүд байгаа.

Дээр нь үнэт цаасны асуудал байгаа. Өөрөөр хэлбэл “**бонд**” байгаа гэсэн үг.

Бондтой холбоотой асуудлыг та хязгаарыг нь тогтоогоод өгчихье гэж бодож байна. Хамаа байхгүй. Ялгаагүй.

Нөгөө талдаа төсөв талаасаа энэ бол Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг бид баталж байгаа. Өр нь Засгийн газрын өрөнд орчхож байгаа учраас бид төсвийн хүрээний мэдэгдэл дээр нийт өрийн хэмжээндээ оруулаад явчхаж байгаа.

Монгол Улсын 2025 оны.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Энэ зүйлүүд дээрээ бас тэгээд Г.Тэмүүлэн гишүүнтэй эргээд сайн яриарай. Та хэд.

Нийтдээ хэдий хэмжээний гадаад бонд гаргах вэ гэдэг асуудал байгаад байна шүү дээ.

3.Мэндсайхан гишүүн асууя.

**3.Мэндсайхан:** Энэ өргөн баригдсан хуулийн өөрчлөлтөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Энэ 14 дээр “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, их өгөгдөл үүсгэх” гээд.

“Үйл ажиллагааг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэхээр их өгөгдлийн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах зорилгоор төрөлжсөн мэдээллийн сантай байна. Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмыг Засгийн газар тогтооно.” гээд оруулчихсан байна л даа.

Засгийн газрын шууд харьяаны агентлаг чинь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарбайгаа шүү дээ.

Энэ чинь өөрөө төрийн болон орон нутгийн өмчийн

- ▷ бүртгэл,
- ▷ хяналт,
- ▷ менежмент,
- ▷ засаглалыг

хэрэгжүүлээд явж байгаа байгууллага байгаа.

Тэгээд заавал Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хажуудаа ийм өгөгдлийн дата байгуулж, өөрийнхөө шууд харьяа агентлагийнхаа эрх мэдлийг өөр дээрээ ингэж татан төвлөрүүлэх ямар шаардлага байгаа юм?

Энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дээрээ төвлөрөөд явчихад юу нь болохгүй байна гэдэг нэг ийм асуулт байна.

Энэ Аж ахуйн нэгжийн орлогын татварын хууль дээр “мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих, виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн хуульд заасан үйл ажиллагааг дэмжинэ” гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр харьяалалгүй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд бас хөнгөлөлт аваад явна гэж ойлгож болох уу?

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Энэ “виртуал бүс”-д гэдэг чинь сая бас нэг тодотголоор орж ирсэн шүү дээ.

Энэ ер нь хэдэн удаа ийм болчихоод байна аа? Давхцал гараад байгаа юм биш биз? Нэмэлт хариулт өгөөрэй бас. Хариулъя. Хэдэн номер вэ? Нэг.



**Д.Саруул:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газар. Д.Саруул. Гишүүний асуултад хариулъя.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газардээр мэдээллүүд төвлөрдөг.

Гэхдээ энэ нь тодорхой хяналтыг хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй мэдээллийг хүргэх мэдээллүүд төвлөрч байгаа.

Тэгэхээр үүнийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд авч байгаа нь Засгийн газраас тодорхой шийдвэр гаргахад чиглэсэн. Өөрөөр хэлбэл мэдээллүүдийг нэгтгээд боловсруулалт хийж, хэрэгжүүлэх энэ чиглэлдээ зөвхөн дата дээр суурилсан мэдээллийг цуглуулах тийм мэдээллийн сан байх юм.

Тэгэхээр энэ хоёр хоорондоо уялдаатай. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газардээр төвлөрч байгаа мэдээллүүд дээр анализ хийх мэдээллийн “төрөлжсөн мэдээллийн сан” байх юм.

**Ц.Даваасүрэн:** Тэр “виртуал бүс”-ийн татварын асуудал дээр. 4 үү? Аан.., 4.

Энэ давхцаад байгаа юу гэдэг дээр нэмэлт хариулт өгөөрэй.

**Б.Тэлмүүн:** 3.Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн.

Энэ асуудал 2024 оны 8 сарын 30-ны өдөр Аж ахуйн нэгжийн орлогын татварын хуульд орсон “нийгмийн шинжтэй хөрөнгө оруулалтын борлуулалтын орлогын 1 хувийн

хөнгөлөлт” гэдэг дээр энэ асуудал яригдсан.

Энэ дээр яасан бэ гэхээр яг энэ хууль өргөн барих үед Мэдээлэл технологийн виртуал бүсийн тухай хууль, түүнийг дагаж орсон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль Төрийн мэдээлэлд хэвлэгдээгүй байсан учраас үүнтэй холбоотой зохицуулалт орхигдоод орчихсон.

Тэгээд Байнгын хорооны хуралдааны үеэр төсөв өргөн барихдаа Байнгын хорооны даргаас төсөв дагуулаад үүнийгээ нийслэлийг нь хангуул гэсэн ийм асуудал орсон байгаа.

Тэгэхээр энэ бол 8 сарын 30-ны өдөр батлагдсан хуульд одоо энэ виртуал бүсэд хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжүүдэд энэ орлогын татварын 1 хүртэл хувийн татварын дэмжлэг үзүүлэх.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Тодруулах юм уу? 3.Мэндсайхан гишүүн тодруулъя.

**3.Мэндсайхан:** Тэр Төрийн өмчийн хороон дээр байгаа мэдээллийг ашиглаад хоорондоо уялдаатай ажиллана гэж байна.

Ингэх юм бол үүнийг зарчмын хувьд бид ямар ч дэмжих боломжгүй л юм байна. Миний хувьд.

Тэнд нэгэнт бүрдчихсэн датаг та нар энд авчирч шийдвэр гаргахад ашиглана гэж байгаа бол тэр танай шууд харьяа агентлаг чинь энэ ажлаа хийгээд явахад юу нь болохгүй байгаа юм. Яагаад ийм давхцал үүсгэх гээд заавал Хэрэг эрхлэхийн хажууд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтынхаа үйл

ажиллагааг татаж ирэх гээд байгаа юм бэ?

Хоёрдугаарт, Б.Тэлмүүн дарга аа, миний асуугаад байгаа нь юу асуугаад байгаа юм. Тэр виртуал бүсэд чинь харьяалалгүй иргэн, гаднын хөрөнгө оруулагч нар ороод явчих юм бол тэр хүмүүс чинь татварын хөнгөлөлт эдлэх юм уу?

Хуулийн чинь хамрах хүрээг харахаар тэр бүсэд бүртгэлтэй л байх юм бол энэ чиглэлийн дэмжлэгийг үзүүлээд явна гэсэн утгатай байгаа шүү дээ.

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. 1 номер. Төрийн өмчийн хорооны бүртгэлтэй холбоотой асуудал.

**Д.Саруул:** Энэ мэдээллийн сан нь өөрөө “Их өгөгдөл”-д суурилсан мэдээллийн сан байх юм. Ялангуяа Засгийн газрын шийдвэр гаргахад чиглэсэн ийм сан байх юм.

Тийм учраас яаралтай горимоор ч гэдэг юм уу, Засгийн газрын гишүүдийг байнгын тогтвортой мэдээллээр хангаж байх. Тийм ээ. Тэр үүргийг хэрэгжүүлж байгаа учраас.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дээр байгаа сан бол

▶ *Нэгдүгээрт, “бүртгэл”-ийн,*  
▶ *Хоёрдугаарт, тодорхой хэмжээний “хяналт” тавих чиглэлийн.*

Мөн “олон нийтэд нээлттэй байх” тэр чиглэлийг агуулсан.

Зорилгын хувьд хоорондоо уялдаатай байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирж байгаа мэдээлэл дээр нэмээд өөр бусад мэдээллүүд орсон буюу “Их өгөгдөл”-д суурилсан мэдээллийн сан байна гэж тооцсон юм.

**Ц.Даваасүрэн:** Мэдээлэл нь хоёулаа ижилхэн юм уу, өөр юм уу?

**Д.Саруул:** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газардээр байгаа мэдээллийн сан дээр суурилагаас гадна нэмэлт бусад мэдээллүүд явна.

Засгийн газар өөрөө цахим шилжилт хийж байгаатай холбоотой.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** 4. Виртуал бүсийн орлогын албан татварын асуудал дээр харьяалалгүй этгээд хамрагдах уу?

**Б.Тэлмүүн:** 3.Мэндсайхан гишүүний асуултад нэмж хариулъя. Сангийн яам Б.Тэлмүүн.

Мэдээллийн технологийн виртуал бүсийн тухай хуулийн 12.1-д зааснаар “...хуулийн этгээд байна. Хуулийн этгээдийн холбогдох мэдээллийг авсны үндсэн дээр Зөвлөлийн ажлын алба бүртгэнэ.” гэдэг ийм нарийвчилсан зохицуулалтуудтай юм билээ.

Тэгэхээр гадаадын хуулийн этгээд энд шууд бүртгэгдээд явах боломжгүй юм байна гэж ойлгож байгаа.

Энэ дээр 12 дугаар зүйл дээр виртуал бүсэд бүртгэх, бүртгэлээс хасуулахтай холбоотой дэлгэрэнгүй зохицуулалт, хуулийн этгээдийн нэр, эцсийн үйлчлэгчдийн мэдээлэл гээд энэ бүх мэдээлэл нь нээлттэй байна гэсэн ийм зохицуулалттай байгаа.

Тэгэхээр Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг энд гадаад, дотоод гэж ялгах боломжгүй байх.

**Ц.Даваасүрэн:** Да.Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

**Да.Цогтбаатар:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Хариуцлагын асуудлыг илүү дэлгэрүүлж ярих хэрэгтэй байх гэж бодоод байгаа юм.

Одоо баахан сумаар эмнэлэг, сургууль, соёлын төв гээд баахан юм барьдаг. Бариад 3 жилийн дараа нураад ойчдог. Би чуулган дээр бүр жишээг нь харуулж байгаад ярьсан. Зурагтаар ч гэсэн гарч байна лээ.

Тэгээд энэ Барилгын тухай хууль дээрээ ч юм уу өөрчлөлт оруулаад, ядахдаа барилгыг 15, 20 жилийн хариуцлагын асуудал барьсан компанитай нь яригддаг байдлаар өөрчлөлт оруулж ирж болохгүй байсан уу гэдэг нэг асуулт байгаа юм.

Хоёрдугаарт нь, Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” гээд байна.

Үүний 1.6 дээр Төрийн банк болон төрийн өмчит бусад санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүргээр шинэчлэн зохион байгуулж, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй төсөл, хөтөлбөр, хэрэглээг урамшуулан дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэх гээд.

Төрийн банканд зориулаад л бид одоо бараг хууль гаргаж өгөх нь холгүй юм яваад байна шүү дээ.

Энэ яагаад бусад арилжааны банкнаас ялгаатай ингэж давуу эрх эдэлж явах ёстой юм. Үүнийг ингэж өөрчилснөөр ямар үр дүнд хүрэх вэ? Эдийн засгийн тооцоолол байгаа юу? Үүнийг ингэж байхаар зүгээр хувьчлаад явуулчхаж болдоггүй юм уу? Бид дахиад л нэг банк тэжээж л явах асуудал яригдаад байна. Ийм хоёр асуулт байна.

**Ц.Даваасүрэн:** Хэн хариулах вэ? Б.Жавхлан сайд хариулах уу? Төрийн банканд тэр барилгатай холбогдолтой нь үүнтэй хамт юм уу?

**Да.Цогтбаатар:** Тусдаа.

**Ц.Даваасүрэн:** Тэр нь нэг нь хариулах хэрэгтэй болох нь байна шүү дээ. Одоо би хариулалтай биш.

Б.Жавхлан сайдын микрофон.

**Б.Жавхлан:** Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулья.

Төрийн банк 100 хувь төрийн өмчит Засгийн газрын ийм банк байж байгаад Засгийн газар, Улсын Их Хурлаас гаргасан чиглэлийн дагуу “хувьцаат компани” болсон.

Одоогоор 5 хувь нь, цаашдаа нэмэгдэнэ. 30 хувь хүртэл нэмэгдэнэ.

Түүнээс хувьчлал гэдэг асуудал бол байхгүй болсон шүү дээ. Нөгөө хуучин шиг нөгөө цүнхтэй хэдэн нөхдүүд хүрч ирээд хувьчилдаг тийм юм байхгүй болсон.

Улсын Их Хурлаас чиглэл гарсан байгаа. Цаашдаа стратегийн хувьд “хувьцаат компани” болгоод үйл ажиллагааны хяналт, үр өгөөжийг нь дээшлүүлээд аваад явах компаниудын жагсаалт гаргачихсан байгаа.

Тэр дагуу тэр хүрээнд “хувьцаат компани” болсон гэсэн үг.

Одоогоор бол 95 хувь нь төрд хэвээрээ байгаа.

Тийм учраас цаашдаа хувьчилна гэдэг ойлголт байхгүй.

Банкны тухай хуульд өөрчлөлт орсон тэр төлөвлөгөөний дагуу 30 хувь болон бусдыг нь 20 хувиар хязгаарлаад тараах тэр энэ тэр бол энэ төрийн өмчит банканд хамаарагдахгүй гэсэн ийм заалттай шүү.

Тэгэхээр энэ заалтуудынхаа л дагуу явна.

Ногоон банк болж байгаа нь та давуу тал гэж тэгж харж болохгүй шүү. Ямар юмных нь давуу тал байх вэ. Харин ч арилжааны банкууд зориглож шууд орохгүй байгаа энэ нэлээн сорилттой ийм зах зээл рүү түрүүлж манлайлал үзүүлж орох гэж байна гэсэн үг.

Энэ нь одоо яг Засгийн газрын хэрэгжүүлж байгаа, дээрээс нь ер нь дэлхий нийтийн чиг хандлага шүү дээ. Одоо бүх л зүйл ногоон руугаа шилжиж байна. Ногоон санхүүжилт, грийн хаусинг.

Тэгээд л ерөөсөө энэ эрчим хүч, бүх энэ шилжилтүүдтэй холбоотой. Үүнийг одоо яг “retail”<sup>[жигжиглэнгийн худалдаа]</sup> түвшинд тэнд бүтээгдэхүүн гаргаж энэ шилжилтүүдийг дэмжих. Үүгээр

бодлогоо цааш нь үргэлжлүүлж явна л гэж байгаа.

Харин ч нийгмийн том ачаалал авч Засгийн газрын чиглэл бодлоготой нийцэж явж байна гэж ойлгох нь зөв байх.

**Ц.Даваасүрэн:** Болсон уу? Барилгын яамнаас хүн байна уу? Алга уу.

Да.Цогтбаатар гишүүний яриад байгаа асуудлыг би Барилгын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бэлдээд үлдээчихсэн байгаа. Наад заалт чинь яг байж байгаа.

Ер нь барилгын салбарыг хариуцлагажуулах заалтууд нэлээн орсны дотор яг наадах чинь орсон байж байгаа. Одоо дутагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр Ерөнхий сайд ойрын үед Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа хуулийн төслүүд нэлээн цөөрчихсөн байгаа учраас хэлэлцье гэж байгаа юм билээ.

Тэгэхээр тэр дээр яг ороод ирнэ наадах чинь.

Ж.Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.

Тэгэхээр дагасан хуулиудыг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэж бодож байна.

Тодруулах ёстой зүйл байсан. Сая Г.Тэмүүлэн гишүүн тодруулаад ерөнхийдөө тогтоолын төсөлдөө тодорхой тоо хязгаартай оруулахаар би тогтлоо гэж ойлгогдлоо шүү дээ. Энэ юун

дотроос чинь. Асуулт хариултын дундаас.

Тэгж явах нь зөв болов уу гэсэн нэг ийм юм байна.

Хоёр дахь зүйл. Тэр Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн тэр 1.22-ын 22.5.22-т заачхаад байгаа “бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн импорт орлох, экспорт дэмжих” тэр үйлдвэрүүдийг 5 жилийн хугацаанд 90 хувиар хөнгөлөх тухай асуудал байгаа юм.

Тэгээд бүсийн ялгавартай татварын бодлогын тухай асуудал яригдаад байдаг.

Гэхдээ бид үзэл баримтлал талдаа бүсүүдийнхээ хөгжлийн төрөлжилт, дэд бүсийн асуудлыг их тодорхой оруулж чадал уу?

Тэгэхээр аль бүс дээр ямар чиглэлийн үйлдвэр нь хөнгөлөлт эдлэх вэ гэдэг асуудал чинь өөрөө их тодорхой болж чадаж байгаа юу гэдэг нэг ийм асуудал байгаад байна.

Хоёр дахь зүйл. Тэр Гаалийн тариф, гаалийн татварын хуульд өөрчлөлт оруулах тухай асуудал дээр 1 дүгээр зүйлийн тэр 38.1.26 дээр “дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал” гэдэг үг орчхоод байгаа юм.

Энэ ер нь ямар агуулгатай орчхов оо?

Би тэр “үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж”-д тэртээ тэргүй гаалийн татвараас чөлөөлөх тухай асуудал дээр нь дэмжиж байгаа.

Энэ “барилгын материал”-ын асуудал яагаад ороод ирэв гэдэг юм байна. Энэ дээр нэг хариулт авъя.

**Ц.Даваасүрэн:** Хэн хариулах вэ? 4.

**Б.Тэлмүүн:** Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Бүсчилсэн хөгжилтэй холбоотойгоор Улсын Их Хурлаас баталсан 2 баримт бичиг байгаа. Энэ хүрээнд энэ хуулийн төслийн заасан татварын дэмжлэгүүд хэрэгжинэ.

Нэгдүгээрт нь, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол. Мөн хэдхэн сарын өмнө баталсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт бас энэ бүсийн чиглэлүүдтэй холбоотой асуудал тусгагдсан байгаа.

Яг энэ хуульд заасан энэ төслүүд бол эдгээр хоёр Улсын Их Хурлын тогтоолын хүрээнд хэрэгжээд явна.

Яг ямар ямар төслүүд гэдэг нь тухайн аймгийн удирдлагууд, гишүүд, тэгээд Засгийн газар дээр ярьж байж Засгийн газрын тогтоолоор эцэслэгдэж батлагдана.

Хоёр дахь асуултын хувьд. Яагаад “барилгын материал” орж байна гэхээр бид ерөнхийдөө татварын дэмжлэгийг дандаа бодитой хөрөнгө оруулалтууд, бодитой бүтээн байгуулалтууд руу нь чиглүүлье гэдэг ийм бодлого баримталж байгаа.

Тэгэхээр бүсчилсэн хөгжлийн энэ том бүтээн байгуулалтууд, төслүүд хэрэгжүүлэхэд хамгийн гол асуудал бол импортын барилгын материал буюу яг нөгөө орлого олж эхлээгүй байхад бараа, материал, барилгын материал татах үед хамгийн том мөнгөн хөрөнгийн хүндрэл учирдаг.

Энэ үед нь барилгын материалын гаалийн болон НӨАТ-ын татварын хөнгөлөлт үзүүлнэ.

Тухайн үйлдвэр ашиглалтад орохтой холбоотой тоног төхөөрөмжүүд энэ хуулийн нөгөө заалтаар дэмжигдээд явчихна.

Нэмж танд мэдээлэл өгөхөд яг бүсчилсэн хөгжлийн томоохон төслүүд энэ гол гол төслүүд хэрэгжүүлэхтэй холбоотой бид бүтээн байгуулалтын үед

► *импортын гааль, НӨАТ-ын татварын дэмжлэг,*

► *үндсэн хөрөнгө бий болсны дараа үл хөдлөх хөрөнгийн албан татварын дэмжлэг,*

► *тухайн төсөл ашиглалтад ороод орлого олж эхлээд, ашигтай ажиллаж эхэлсэн эхний 5 жилд дахиад орлогын татварын дэмжлэг*

гээд ийм татварын цогц дэмжлэгийг бүтээн байгуулалт, ашиглалтын үе шат болгонд нь илүү оновчтой, бодитой байдлаар үзүүлэхийг л зорьж байгаа.

Тэгснээрээ яг бүсчилсэн хөгжлийн энэ үзэл баримтлал, энэ төслүүд амжилттай хэрэгжинэ гэж үзэж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Ж.Батжаргал гишүүн тодруулъя. Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье.

**Ж.Батжаргал:** Тийм. Баялаг бүтээж байгаа салбар энэ юмаа бид дэмжих ёстой.

Тэгээд энэ нэр доор жаал бий болгосон үндэсний юмнуудаа устгачих гээд айлгаад ерөөсөө болохгүй юм.

Өнгөрсөн жил цементийн үнэ бууруулж байгаа нь энэ гээд татварыг нь бид бууруулаад жаал үндэснийхээ цементийн үйлдвэрүүдийн борлуулалтыг хаачхаж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ зүгээр нэг цементийн асуудал биш байхгүй юу. Цаана нь хүний ажлын байр, энэ эдийн засгийн чинь идэвхжил, энэ бүх юманд нөлөө үзүүлж байгаа зүйл шүү дээ.

Ийм байдлаар энэ асуудлуудад хандаад явж болох юм уу? Энэ үндэстэн үнэхээрийн тусгаар улс юм бол өөрийн гэсэн эдийн засагтай, өөрийн гэсэн чадамжтай байх тухай л асуудал. Түүнээс бид худалдааны эдийн засаг шүтчихсэн ийм байдлаар амьдармгүй л байгаа байхгүй юу. Үүнийгээ нэг бодмоор.

Хоёрдугаарт, бид төрийн өмчийн үр ашгийг сайжруулах тухай их ярьж байгаа.

Гэхдээ гаднын зөвлөх үйлчилгээ, гаднын менежмент шүтэх гэсэн оролдлого орж ирээд болохгүй юм. Энэ одоо юу гэж ойлгох юм бэ. Аудит ярихаар дандаа гадны.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Тийм. Нөгөө импортын татвараар үндэсний үйлдвэрлэгчээ дэмжихгүй байна гэсэн



шүүмжлэл байна шүү дээ. Тийм ээ. Нэг дэх нь.

Хоёр дахь нь, тэр зөвлөхийн асуудлыг заавал гаднаас.

Хэн хариулах юм? Б.Жавхлан сайд. Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Тийм.

Тэгэхээр манай эдийн засаг маань өөрөө “гадаад худалдааны эдийн засагтай улс”.

Бид маш олон жил “үйлдвэрлэгч улс больё”, “экспортлогч улс больё” гэж ярьж байгаа боловч түүндээ хүрч чадахгүй л байгаа.

Гадаад худалдааны ганц хэрэгсэл нь ерөөсөө энэ импорт, экспорт, үүнийг дагасан татварын л зүйлүүд байдаг.

Ялангуяа барилгын салбар дээр бид үндэсний үйлдвэрлэгч болох 2 том л бүтээгдэхүүн байгаа. Цемент, арматур гээд. Төмрийн бүтээгдэхүүн гээд.

Цемент дээр уг нь үндэсний үйлдвэрлэгчтэй больё гээд бид сүүлийн ер нь 10-аад жил Хөгжлийн банкны гашуун түүх ч байна. Татвараар ч тэр, НӨАТ-аар ч тэр.

Үндсэндээ 25 хувийн хөнгөлөлт үзүүлээд, дээрээс нь зээлийн хөнгөлөлт үзүүлээд явж ирсэн.

Харамсалтай нь хэдийгээр хүчин чадал нь дотоодын хэрэгцээгээ хангах боломжтой боловч та 2023 оны болсон зүйлийг ярьж байна. Тийм ээ. /минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Б.Жавхлан сайдад 1 минут нэмж өгье.

**Б.Жавхлан:** Тэр үед юу болсон бэ гэхээр хэдийгээр дотоодын зах зээлээ бүрэн хангах боломж байсан хэдий ч тэр үед. Тэр чинь аль агентлаг дээрээс билээ.

Энэ дээр нөгөө өрсөлдөөний хууль зөрчсөн байна. Тэгээд энэ дээр ийм хомсдол үүссэн байна гэсэн иймэрхүү дүгнэлтүүд гарсан.

Энэ дагуу Барилга, хот байгуулалтын яамнаас орж ирж байсан саналыг бид дэмжиж энэ татварын асуудлуудыг авч хэрэгжүүлж байсан.

Тэгэхээр өөрөөр хэлбэл эндээс юу харагдаж байна вэ гэхээр энэ импортын татварын юм чинь ерөөсөө 3 зүйлээс шалтгаална.

- *Дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадлын хэмжээ,*
- *Импортлох боломж,*
- *Дотоодын эрэлт, хэрэгцээ.*

Ийм 3 балансыг харж байж бид үүнийгээ тогтоож явах учиртай юм.

Хэт үндэсний үйлдвэрлэлээ бид дэмжинэ гээд, үүний цаана юу болдог вэ гэхээр үнэ өсдөг. Ингээд хэрэглэгч хувирдаг.

Тэгээд энэ 3-ын баланс нь өөрөө яг хэрэглэгч нартаа нийцсэнсэн.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Б.Заяабал гишүүн асуултаа асууя.

**Б.Заяабал:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Үнэт цаастай холбоотой асуудал дээр сая асуулт давхацчихлаа.

Би энэ дээр татвартай холбоотой нэг асуулт асуух гээд байгаа юм.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр “Үндэсний бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бол дахиад 5 жилийн хугацаанд 90 хувийн хөнгөлөлт үзүүлнэ.” гэдэг ийм заалт орж ирж байгаа юм.

Үүнтэй холбоотой би дэлгэрүүлээд жоохон асуух гээд байгаа юм.

Энэ жагсаалтыг нь Засгийн газар батлах юм байна. Засгийн газрын баталсан “бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн” гэдгээр нь 90 хувийн хөнгөлөлт үзүүлээд явах юм байна гэж ойлголоо.

Нэгдүгээрт, татвар талдаа хийдэл үүсгэх нэг аюултай цонх харагдаад байна л даа. Нэгдүгээрт.

Энэ талаараа юу гэж бодож байгаа юм бэ гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, 5 жилийн энэ 90 хувийн хөнгөлөлт чинь манай баруун бүсэд жишээлбэл ямар ч үйлчлэлгүй болчихоод байна л даа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар Улаанбаатар хотоос мянган километр алсад байвал угаасаа 90 хувийн хөнгөлөлттэй байгаа.

Тэгээд нэг ийм дүр эсгэсэн ийм хөнгөлөлтийн заалт орж ирээд байдаг.

Өнөөдөр яг энэ бүсүүдийг аваад үзэхэд манай баруун бүс хамгийн их

ядуурлын түвшинтэй. Нийт бүсүүдээр аваад үзэхэд хамгийн өндөр ядуурлын түвшинтэй буюу 36.5 хувийн ядуурлын түвшинд амьдарч байна гэсэн ийм статистикийн судалгаа тоо мэдээ нь байгаад байдаг.

Манай баруун бүс жилдээ нийтдээ 4 их наядын борлуулалт хийдэг. Үндсэндээ бараг 90 хувь нь дандаа худалдаан дээр суурилсан эдийн засгийн бүтэцтэй. Үйлдвэрлэл ерөөсөө байхгүй.

Тэгээд нэг ийм бодлого яваад байгаа юм.

Тэгээд үүнтэй холбоотойгоор яг хэчнээн аж ахуйн нэгжид та нар энэ хөнгөлөлт хамаарна гэж үзэж байгаа юм? Хэчнээн хэмжээний төлөх байсан орлого нь аж ахуйн нэгжид нь хөрөнгө оруулалт хэлбэрээр үлдэхээр байгаа юм бэ гэсэн нэгдүгээр ийм асуулт байна.

Хоёрдугаарт нь, тэр тогтоолтой холбоотой асуулт бас байгаа юм.

“Ургамал хамгааллын газрыг байгуулна” гэдэг ийм орж ирээд байдаг. Ингээд аваад үзэхээр зорилго нь юу юм бэ гэхээр зэрэг “ургацын хэмжээг нэмэгдүүлнэ”, “хүн амын хэрэгцээний дотоод үйлдвэрлэлийг хангана” гэсэн ийм л зорилтууд л яваад байна л даа.

Гэтэл манай монголчууд чинь хавдраараа хамгийн өндрөөр одоо тооцогдож байгаа. Нийт хүн амд ноогдох хавдрын өвчлөл хамгийн өндөр.

Яг үнэндээ “монгол хүн” бид эм, хүнсний зүйлүүдээ яг хэр зэрэг найдвартай зүйл идэж байна вэ, үүнийг яг ямар байгууллага тогтоож байна вэ гэдэг нь тодорхойгүй яваад байдаг.



Гэтэл нөгөө талаасаа энэ бэлтгэн нийлүүлэлтийг хангасан ийм төрийн байгууллагууд нэмэгдээд байгуулагдаад байдаг. Эргээд энэ нь Засгийн газрынхаа зардлыг нэмэгдүүлдэг, зарцуулалтыг нэмэгдүүлдэг.

Зарлага нэмэгдэж байгаа цагт орлогыг нь бууруулах, татварыг нь бууруулах, хөнгөлөх ямар ч боломж байхгүй шүү дээ. Иймэрхүү бас ийм уялдаагүй Засгийн газрын тэлсэн зүйл явж байна уу гэж харж байна.

Гуравдугаарт нь, төрийн болон орон нутгийн өмчийн.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Эхний 2 асуултад нь хариулъя. Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Гишүүний асуултад хариулъя.

Та Татварын ерөнхий газрын даргыг олон жил хийсэн хүн. Уг нь энэ талын асуудлуудаа ойлгомоор юм.

Энэ бодлогын шилжилтүүд чинь зөвхөн татварын орлогоо дагаж биш зах зээлийн хуваарилалт, бүсчилсэн хөгжлийн хоорондоо кластерлаж хөгжих, бүс бүрт тэргүүлэх чиглэлүүдийг нь өөрсдөө гаргаж ирж сонгож, тэрийгээ дагаж зах зээлийг нь дэмжих ийм бодлого шүү дээ.

Тэгэхээр тэнд нэг дүр эсгэсэн гэж, тэгж басамжилж энэ бодлогыг бас болохгүй.

Хэрвээ бид “Бүсчилсэн хөгжил” гэж үзэл баримтлалаа батлаад тэр лүүгээ шилжээд явж байгаа бол тэр алслагдсан аймаг ч бай тэр чинь ганц үйлдвэрлэл биш. Энэ татварын бодлогоор чинь

дамжаад тэр бүс нутгийг чинь дэмжсэн, зах зээлийг нь дэмжсэн өөр бодлогууд ч явна.

Одоогоор тэр 900 километрээс цааш алслалттай аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг 90 хувь хөнгөлнө гэдэг дээр аж ахуйн нэгжүүд ер нь бараг хамрагдахгүй байгаа.

Яагаад гэвэл өөрөө нөгөө зах зээлээсээ хол учраас хөнгөлөгдсөн ч гэсэн, хөнгөлөгдөөгүй байсан ч тэр энэ Улаанбаатар том зах зээлээ дагаад байж байсан нь өөрсдөд нь илүү ашигтай байгаа учраас тийшээ явахгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ “бүсчилсэн хөгжлийн татварын бодлого” чинь өөрөө энэ татцалыг л тийш нь шилжүүлэх гэж байгаа асуудал. Ганц нэг татвар чинь өөрөө тэнд хүч нь хүрэхгүй байна гэсэн үг. Таталцалыг бий болгож чадахгүй байна гэсэн үг.

Тийм учраас энэ өөрөө аягүй олон бодлогуудтай нийлж тийшээгээ чиглэсэн бодлого явах учраас одоо үр дүнг үр дүн гарсан хойно нь л мэдээж хэлнэ гэж та хэлэх байх.

Одоогоор энэ бүтцийн хөгжлийнхөө бид маш том шилжилт, энэ бодлогын том бичиг баримтуудаа Засгийн газрын 4 жилийнхээ мөрийн хөтөлбөртэй ч уялдаад, Улсын Их Хурлаас гаргасан энэ тогтоолынхоо хүрээнд ч тэр төсвийн бодлого маань өөрөө үүнийг дэмжиж ингэж орж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ үр дүнгийн төлөө дахиад хийгдэх, төсвөөс гадна энэ чинь хийгдэх маш олон ажлууд байгаа.

Энэ бүсчилсэн хөгжлийг дангаараа хариуцдаг сайдтай болсон. Сайд өөрөө Үндэсний хороотой болсон. Энэ Үндэсний хороонд бүс бүсийг төлөөлж гарч ирсэн одоо хамгийн том төлөөллүүд иргэдийн төлөөллүүд, бүс нутгийн төлөөллүүд, Улсын Их Хурлын гишүүд ч өөрсдөө энд оролцоод явна.

Тэгж байж энэ бүгдээрээ ингэж цогцоороо нэг зорилгын төлөө ингэж нэгдсэн бодлоготой уялдаж үр дүн гарна гэж бодож байна.

Түрүүн тэр яагаад “гадаадаас зөвлөх үйлчилгээ авъя” гээд байгаа маань.

Ер нь энэ ийм учиртай шүү. Гаднаас ч авч болно, дотоодоос авах ч бас нэлээн байгаа.

Ер нь дэлхий нийтийн даяаршил, энэ глобалчлалын л асуудал байгаа. Энэ бүс нутгийн ч асуудлууд байгаа.

Хэрвээ бид олон улсын зах зээл дээр гаръя гэвэл тэдний дүрмээр тоглох хэрэгтэй. Тэдэнд тоогддог тэр зөвлөх үйлчилгээг, тоогддог аудитын газруудаар үнэлэгдсэн байх ёстой.

Одоо тухайлбал Засгийн газар өнөөдөр ингээд 3 зээлжих зэрэглэлийн компаниар үнэлгээ хийлгэдэг юм. Үнэтэй л дээ. **Fitch Ratings**, **S&P Global**, **Moody's ANALYTICS** гээд. Зуу зуу гаруй мянган долларын үнэтэй.

Үүнийг цаанаас өөрөө зах зээл, дэлхий өөрөө хөрөнгийн зах зээл шаарддаг, хөрөнгө оруулагч нар шаарддаг.

Монгол Улсын Засгийн газар 2010 онд “Чингис бонд” гээд түүхэндээ анх

удаа олон улсын хөрөнгийн бирж дээр Засгийн газрын кодтой болсон.

Маргааш нь эхлээд л олон улсын хөрөнгө оруулагч бид нараас ийм үнэлгээ хийхийг шаардаж байдаг. Гэх мэтчилэн.

Одоо жишээ нь, Хөрөнгийн бирж, Төрийн банк, Хөгжлийн банк гээд.

Ер нь олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдоод тэндээс хөрөнгө оруулалт татдаг ийм институцүүд олон улсын байгууллагаас яг тэднийх нь хэлээр гадаад зах зээл дээр бид нарыг үнэлж өгөх, харуулж өгөх тийм институцүүдтэй холбогдож зөвлөх үйлчилгээ авч явахаас өөр арга байхгүй. Тийм.

Тийм учраас энэ дээр бүгд хавтгайраад гэнэт нэг өдөр сэрээд бүгд тийшээ шилжих биш үнэхээр яг гадна талдаа холбогдох энэ сувгууд дээр бол одоо бид ийм үйлчилгээ авахаас өөр аргагүй ийм ирээдүй л биднийг хүлээж байгаа. Ийшээгээ бид явж байгаа л гэж хэлэх юм даа. Тийм.

**Ц.Даваасүрэн:** Тэр ургамал хамгаалал дээр нь хэн хариулах юм.

**Б.Жавхлан:** Тэр чинь хууль нь гарсан. /минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** 1 номер.

**Д.Саруул:** Ургамал хамгааллын хуулийг шинэчилж найруулаад Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль гээд 2024 оны 6 сард батлагдсан байгаа.

Тэгэхээр энэ хууль дээр яг энэ ургамал хамгааллын асуудлыг хариуцсан бие даасан агентлагтай байхаар тусгагдаж

орж ирсэн. Хуульчлагдсан. Тэгээд энэ дагуу агентлагийг нэмж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Наадах чинь нөгөө хэмнэлтийн хуультай ямар нэг зөрчил байх уу?

**Д.Саруул:** Байхгүй. Хууль дээр нь өөртөө яг бие даасан агентлагтай байхаар хууль нь баталчихсан.

Тэгээд энэ болохоор 2024 оны 6 сард батлагдсан хууль байгаа. Тэгээд үүнийг нэмж оруулж ирж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Наадах чинь чухал нь чухал. Ялангуяа манайд хамгийн их дутагдаж байгаа юм болохоор бэлчээрийн ургамал ингээд устаад байгааг манайд ерөөсөө судлахгүй байгаа байхгүй юу. Одоо манай газар зохион байгуулалтын алба л нэг судалдаг. Хөдөө аж ахуйн яам нь өөрөө судалдаггүй тийм юм билээ.

Тийм учраас энэ ямар ургамал нь. Одоо адууны мах хүртэл өөр амттай. Хуучин бол аягүй аагтай, үнэртэй байдаг байсан байхгүй юу. Одоо аагтай үнэр байхгүй. Яагаад гэвэл тэр ургамал нь устчихсан байгаа байхгүй юу.

Тийм учраас л тэр ургамлуудыг нь сэргээдэг, нөхөж тарьдаг, хамгаалдаг ийм л болох шаардлагатай гэдэг агуулгаар байх.

Тодруулъя. Б.Заяабал гишүүн.

**Б.Заяабал:** Тэгээд тэр саяын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн гэдэг тэр ангилалд багтах ангилалыг Засгийн газар тогтооно гээд хэлчихлээ.

Тэгэхээр түүн дээрээ хийдэл үүсэх вий дээ. Түүн дээрээ Та бүхэн бас анхаараарай.

Дээрээс нь үндсэн үйл ажиллагаа нь Улаанбаатар хотод явагддаг ийм аж ахуйн нэгж баруун бүсийн үндсэн үзэл баримтлалд нь нийцчихсэн үйл ажиллагааг туслан гүйцэтгэх маягаар явах юм бол энэ хөнгөлөлтөд хамрагдах юм уу?

Нийт хэчнээн аж ахуйн нэгж хамрагдахаар байгаа вэ гэсэн ийм асуулт байна.

Дээрээс нь, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээр орж ирж байгаа заалтууд байна.

Өнгөрсөн жил Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж гарч ирсэн. Энэ дээр төрийн болон төрийн өмчит оролцоотой аж ахуйн нэгжүүдийн бүх мэдээллийг ил тод байхаар оруулаагүй юм уу?

Хоёрдугаарт нь, Засгийн газрын тогтоол дээр төрийн өмчийн өмч хувьчлалын үндсэн чиглэлийг оруулж ирнэ гэж байгаа юм. Энэ дээрээ.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Гишүүд гарч яваад байна шүү. Үүний дараа хууль бүрээр дэмжих санал хураалт явна.

Тийм учраас гишүүд гарч явахгүй байхыг хүсье. Хариулъя. Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Хэдэн компани орох вэ, ер нь ямар салбарууд орох вэ гэдгийг Улсын Их Хурлын гишүүдийн нэлээн нөлөө, оролцоотой байдлаар энэ цаашаагаа явна.

Одоо жишээ нь С.Амарсайхан сайд дээр энэ жил төсвийн тодотголоор батлагдсан бүс нутгийн тэргүүлэх чиглэлийн тэр бүтээн байгуулалтууд, жишээ нь гишүүд өөрсдөө саналаа өгөх, тэрийгээ орон нутагтайгаа, бүс нутагтайгаа холбох, түүндээ тааруулсан зураг төсөв, ТЭЗҮ-г хийх. Энэ чинь л одоо яг тэр загвар нь гэсэн үг.

Татвар дээр ч гэсэн адилхан.

Одоо бид нарт тодорхой чиглэл гарчихсан юмнууд одоогоор байхгүй. Ямар ч байсан бодлогоо зарлачихсан. Бүс нутаг дээр хаана, хаана, ямар тэргүүлэх чиглэлүүд байх вэ, тэнд нь хичнээн аж ахуйн нэгж, компаниуд оролцох боломжтой байна. Тэр юмнууд ингээд судалгаагаар шийдвэрийнхээ түвшинд гараад явна.

Дээрээс нь орон нутгийн захиргаа, орон нутгийн удирдлагууд, иргэдийн Хурал, Засаг даргын Тамгын газар гээд. Эдгээр институцүүд маш чухал оролцоно. /минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Ер нь яах вэ тэр татвар дээр Б.Заяабал гишүүний хэлээд байгаа тэр нэг анхаарах юм бол ийм жижигхэн цоорхойг хаана хамгийн их ашигладаг вэ гэхээр орон нутагт.

Орон нутгийн татварын дарга нутгийн хүн байдаг. Нутгийн Засаг дарга байдаг. Тэгээд тэд нарын одоо жишээлбэл хүрээллийн компаниуд татвараас зайлсхийх ийм боломжийг яг тийм замаар их гаргадаг юм байна лээ. Бид нарын хийсэн шалгалтаар. Хэдэн арван тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн мөртөө 3-хан сая төгрөгийн татвар төлсөн компани хүртэл байж байгаа байхгүй юу.

Тийм учраас ер нь орон нутагт уг нь татварын албыг босоо тогтолцоогоор өөр нутгийн хүн л тавьдаг болох хэрэгтэй юм билээ. Тэгэхгүй бол яг ийм шалтгаанаар.

Одоо жишээ нь хэнийг хамруулах вэ гэдгээ шийдчихэж байгаа байхгүй юу. Тэгэнгүүт яг ийм цоорхойгоор аваачаад л хамруулаад хаячхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг бас Б.Жавхлан сайд анхаараарай.

Дараагийнх нь Б.Түвшин гишүүн асуултаа асууя.

**Б.Түвшин:** Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиас хоёр асуулт асууя.

2.3 их наядаар “Ирээдүй өв сан”, “Хуримтлалын сан”-д энэ жил сан нэмэгдүүлэх гэж байгаа юм байна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр –

- ▶ *Эхний үлдэгдэл нь ер нь хэд байсан?*
- ▶ *Одоо энэ нэмэгдээд хэд болох вэ?*
- ▶ *Үүнд тооцох өгөөжийг хаана яаж бүртгэж байна?*
- ▶ *Энэ сангийн мөнгөнүүд хаана ямар валютаар, ямар өгөөжтэй, эсвэл юу юунд хөрөнгө оруулсан байгаа вэ?*

гэдэг талаар нэгдүгээрт, мэдээлэл өгөөч.

**Хоёрдугаарт,** нийгмийн даатгалын сангийн тухай бас хоёр асуулт асууя.

Нийгмийн даатгалын сангийн орлогыг 4.4 их наяд, зарлагыг нь 5.8 их наяд гээд улсаас олгож байгаа дотаци нь 1.4 их наяд гэж ойлгож байна.

Тэгэхээр улсаас дааж байгаа буюу төрөөс дааж байгаа даатгуулагчийн тоо, тэр төрөөс дааж байгаа даатгуулагчаас буцаагаад даатгал авч байгаа, тэр даатгалын санд үзүүлж байгаа нөлөөлөл нь хэр байдаг юм бол оо? Тэр талаар нэг статистик гаргаж тоогоо өгөөч ээ.

Өөрөөр хэлбэл яг энэ “даатгалын санд даатгал төлдөггүй”, “төрөөс даана” гэсэн ангилалтай хүмүүсийн авч байгаа болон оруулж байгаа хувь нэмэр ямархуу байна вэ гэсэн үг.

**Гуравдугаарт,** Эрүүл мэндийн даатгалын сан маань алдагдалтай.

- *Төрөөс 1.3 их наяд,*
- *Даатгуулагчаас 1.2 их наяд цуглаад ингээд 2.5-ийг зарж байна гэж ойлгож байна.*

Тэгэхээр яг энэ эрүүл мэнд, эмнэлгийн байгууллагуудын тусламжтайгаар яг гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, тэгээд анхан шатны эмнэлгийн тусламжуудыг санхүүжүүлсэн гэж яриад байдаг.

Гэтэл эрүүл мэндийн тогтолцоо чинь өөрөө буруу байгаа юм биш үү?

Яг одоо энэ даатгалын асуудал чинь өөрөө эрсдэлд суурилсан, даатгуулж төлөгчийн яг тэр шууд зардлыг нь санхүүжүүлэхгүйгээр, ялангуяа эрүүл мэндийн байгууллагуудын цалин хөлс,

одоо тэгээд магадгүй бусад үйл ажиллагааны зардал.

Дээрээс нь одоо тэр гүйцэтгэлийн тоотой уялдуулаад одоо ингээд бүх иргэд рүү хамаарсан эрүүл мэндийн үзлэг, оношилгооны суурь урсгал зардлыг санхүүжүүлээд байх юм бол энэ чинь угаасаа алдагдалтай байх юм биш үү.

Яг энэ даатгалаар санхүүжүүлэх зардлыг нь яг юу гэж үзэж байгаа вэ?

Энэ гурван асуултад хариулж өгөөч.

**Ц.Даваасүрэн:** Хариулья. Аль микрофон эхлэх вэ? 3 номерын микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Б.Түвшин гишүүний асуултад хариулья.

Эрүүл мэндийн даатгалын сан болон Нийгмийн даатгалын сангийн хувьд аль алинд нь төсвөөс дотаци өгч байгаа.

Тэгэхдээ кэйс нь яг ижилхэн. Энэ юу гэхээр жишээ нь, Эрүүл мэндийн даатгалын сан бол 0-ээс 18 насны хүүхдийн Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс даахаар заачихсан байдаг.

Дээрээс нь тэтгэвэрт гарсан ахмадуудын шимтгэлийг даахаар заачихсан байдаг.

Нөгөө талдаа төр ийм ийм эрүүл мэндийн үйлчилгээг даана гээд хуульчилчихсан байдаг.

Жишээ нь, энэ дээр хавдрын үйлчилгээ ч байдаг юм уу. Тийм ээ. Хүүхдийн вакцины үйлчилгээ, урьдчилан сэргийлэх анхан шатны буюу одоо бид нарын хэлдгээр сум, өрхийн эмнэлгийн үзүүлдэг үйлчилгээг даана гээд заачихсан байдаг.

Ингэхээр өөрөөр хэлбэл Эрүүл мэндийн даатгалын санд орж байгаа орлого хаанаас орж байна гэхээр 18-аас тэтгэвэрт гарах насанд хүрч байгаа хүртэл ажил хийж байгаа энэ хүмүүсийн шимтгэлээс өөрөөс нь 2 хувь, ажил олгогчоос 2 хувь орж байгаа гэсэн үг.

Нийтдээ Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2.4 их наяд орчим ирэх жил очиж байгаа.

Орлогын харьцаа нь талыг нь төсвөөс, талыг нь шимтгэлийн орлогоор. Ийм л процесстой явж байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл манай Засгийн газар болон Монгол Улс өөрөө аль аль сегментийг чухалчилж үзэж байна түүн дээрээ төр энэ шимтгэлийг нь даана гээд л явчихсан ийм л зүйл.

Нийгмийн даатгал үүнтэй ижилхэн кэйс. Жишээ нь, “цэргийн албан хаагчид” бол нийгмийн даатгалын шимтгэл огт төлдөггүй. Энэ хүмүүсийн шимтгэл төлөөгүй учраас тэтгэвэрт гарах боломжгүй болчихно. Ингэхээр тэтгэврийг нь Нийгмийн даатгалын сангаар дамжуулаад төр даана гэсэн хуультай.

Ингэхээр энэ дээр **400 орчим тэрбум төгрөг** бид өгөхөөс өөр аргагүй болно.

Мөн нийгмийн цөөнх болсон жишээ нь “цаатан иргэд”-ийн асуудал байна.

Мөн хүн амаа өсгөх бодлогын хүрээнд хүүхдээ гэртээ харж байгаа ээж нарын нийгмийн даатгалын шимтгэлийг бид тасалдуулахгүйн тулд төрөөс талыг нь өгөөд явдаг. Гэх мэт ийм байдлаар шийдвэр гаргачихсан байдаг учраас энэ шийдвэрийнх нь дагуу бид төрөөс мөнгө өгөөд явдаг.

Нийгмийн даатгалын санд төсвөөс ирэх жил **1.4 их наяд** төгрөгийн дотаци өгнө. Ингэж байж гарах ёстой үйлчилгээгээ Нийгмийн даатгалын сан хийгээд явна.

Мэдээж дийлэнх хэсэг нь Эрүүл мэндийн даатгалын сангийн хувьд талын төрөөс, Нийгмийн даатгалын сангийн хувьд бараг 30-аад хувийг нь төрөөс даагаад явж байгаа үед үүнийг илүү орлогоороо зарлагаа нөхдөг болох.

Өөрөөр хэлбэл зөвхөн шимтгэлийн орлогоороо бусад зарлагаа хаадаг болох, төсвөөс огт мөнгөө авахгүй байх гэдэг тогтолцоо руу орох. Ялангуяа залуучуудын хүсэн хүлээж байгаа буюу “нэрийн данс”-д мөнгөтэй болох, өөрийнх нь төлсөн шимтгэлээ буцаад тэтгэвэрт гарсных нь дараа өөрөө авах энэ тогтолцооны шилжилт рүү шилжихэд маш том хүндрэл үүсэж байгаа.

Нийгмийн даатгалын сан өөрөө хуваарилалтын тогтолцоотой сан учраас бидэнд хүндрэл үүсэж байгаа.

Цаашдаа үүнийг нэг жилийн хугацаанд буюу 2 жилийн хугацаанд, эсвэл 5 жилийн хугацаанд ч хийдэг шинэчлэл биш болж таараад байгаа.



Манайх сүүлийн бараг 10-аад жилд Дэлхийн банктай яг энэ Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгал дээр голлон ажилласан.

Энэ дээр тогтолцооны өөрчлөлтийг яаж хийх вэ, хэдэн хувиар хийх вэ.

Ингээд гол 3 параметр байгаа.

- ▷ *ажилласан жил байгаа,*
- ▷ *шимтгэл төлж байгаа хэмжээ байгаа,*
- ▷ *нэмэгдүүлэн тооцох, бууруулан тооцох*

гэдэг энэ тогтолцоо маань өөрөө яаж явах вэ гэдэг дээр хүн амын тогтолцоотойгоо их уялдах ёстой болчихоод байгаа.

Манай насжилт уртсаад байгаа. Бидний дараа үе маань бид нараас илүү цөөн хүн ажиллахаар тооцоо гарч байгаа.

Мэдээж хэрэг цалингийн зардал өсөх боловч ийм болчихоод байгаа.

Тэгэхээр энэ бол өөрөө их том шинэчлэлийн асуудал болно.

Засгийн газар Улсын Их Хуралтай хамтраад хамтдаа энэ шинэчлэлийг хийгээд явах эрмэлзэлтэй байгаа.

**Ц.Даваасүрэн:** Б.Түвшин гишүүн тодруулъя.

**Б.Түвшин:** Яг энэ асуулт дээр М.Санжаадорж даргатай санал нийлээд байгаа юм.

Өөрөөр хэлбэл Эрүүл мэндийн даатгалын сан алдагдалтай гэж яриад байдаг. Бодит байдал дээрээ төрөөс даах үйлчилгээнүүдийг бид оруулчихдаг.

Эрүүл мэндийн тогтолцооны суурь төрийн үзүүлэх үйлчилгээний тодорхой хэсэг зардлыг бас энэ даатгалын сан руу хуваарилдаг.

Ялангуяа тэр 0-ээс 18 насны болон одоо тэр тэтгэвэрт гарсан хүмүүсийн эрүүл мэндийг даах тэр зардлыг энэ сан руу оруулах нь өөрөө яг энэ сангийн оролцогчийн асуудал биш болох гээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ Эрүүл мэндийн даатгал болон Нийгмийн даатгалын тогтолцоог зайлшгүй яаралтай шинэчлэхгүй бол. Ядаж нэр томъёог нь оруулахгүй бол болохгүй нь байна шүү дээ.

Нийгмийн даатгал бас яг л адилхан л байна л даа. Саяын тэр даатгалын оролцогч биш хүмүүс, иргэний төрөөс гаргасан шийдвэрүүд байж болно.

Гэхдээ энэ нь өөрөө улсын төсвөөс гарах тийм зардлын буюу дотацийн шинж чанартай зардлыг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлж байж нийгмийн даатгалыг өөрөө бид алдагдалтай байна, энэ их хэмжээгээр нэмэгдэж байгаа.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Баялгийн сангаас. 6 номер.

**С.Тулга:** Сангийн яамны хэлтсийн дарга С.Тулга. Б.Түвшин гишүүний асуултад хариулъя.

Оны эцсээр “Ирээдүйн өв сан”-гийн нийт үлдэгдэл **3.9 их наяд** төгрөгт хүрэхээр байгаа.

Одоогийн байгаа үлдэгдэл **3.6 их наяд** төгрөгтэй тэнцэж байгаа.

“Хуримтлалын сан”-гийн үлдэгдэл одоогийн байдлаар **499.5 тэрбум** төгрөг байгаа.

▪ 2025 онд:

→ “Ирээдүйн өв сан”-д **1.8 их наяд** төгрөгийн орлого орно.

→ “Хуримтлалын сан”-д ногдол ашгаар **507.0 тэрбум**, хүүгийн орлогоор **55.0 тэрбум**.

▪ 2025 оны эцэст:

→ “Ирээдүйн өв сан”-гийн үлдэгдэл **5.8 их наяд** төгрөгт,

→ “Хуримтлалын сан”-гийн үлдэгдэл **1 их наяд 61.6 тэрбум** төгрөгт хүрэх ийм төлөвтэй байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тодруулъя. Б.Түвшин гишүүний микрофоныг өгье.

**Б.Түвшин:** Тэгэхээр асуусан асуулт ингэж байгаа шүү дээ.

Сая эхний үлдэгдэл, эцсийн үлдэгдэл, тэгээд орлогоо хэлчихлээ.

**5.8 их наяд, 1 их наяд 61 тэрбум** байгаа юм байна.

▶ *Энэ мөнгө хаана хаана, ямар валютаар ямар өгөөжтэй байна вэ?*

▶ *2024, 2025 оны өгөөжийг хаана яаж бүртгэж байна вэ?*

▶ *Юунд хөрөнгө оруулсан байна вэ? гэж асууж байгаа.*

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. 6 номерын микрофон.

**С.Тулга:** “Ирээдүйн өв сан”-гийн үлдэгдэл 1.8 их наяд бол Төв банкны

долларын “Ирээдүйн өв сан”-гийн валютын дансанд байгаа. 1.8 их наяд Төрийн сангийн дансанд байгаа.

2024 онд багтааж Төрийн сангаас Ирээдүй өв сангийн Монголбанкн дахь долларын дансанд үүнийг байршуулна.

“Хуримтлалын сан”-гийн хувьд Төв банкн дахь Төрийн сангийн “Хуримтлалын сан”-гийн дансанд байршиж байгаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу “Хуримтлалын сан”-гийн үлдэгдэл бодлогын хүүгээс багагүй хэмжээний өгөөж тооцохоор хуульчилсан байгаа.

“Ирээдүй өв сан” бол дотоодод хөрөнгө оруулалт хийх нь хориотой. Зөвхөн гадагшаа хөрөнгө оруулалт хийнэ.

Гадагшаа хөрөнгө оруулалт хийхдээ бид аюулгүй байдал, хөрвөх чадвар энэ хоёрыг зэрэг хангасны үндсэн дээр эрсдэл, өгөөжийн хэмжээг тооцож хөрөнгө оруулалт хийхээр хуульчлагдсан байгаа.

Тэгээд гарах хөрөнгө оруулалтын хэмжээ маань гадаад валютын нөөцийн хэмжээтэй бас уялдаж гарахаар байгаа.

**Ц.Даваасүрэн:** Б.Жавхлан гишүүн тодруулга хийе.

**Б.Жавхлан:** Тийм. Ер нь 100 хувь Монголбанкн дээр байгаа л гэж ойлгох хэрэгтэй.

Тэр “Төрийн сан” гэж тусад нь хэлээд байгааг Монголбанкн дээр гэж ойлгоорой.



Тэгэхдээ энэ дээр ерөнхий чиг хандлагыг нь би бас нэг хэлэхгүй бол болохгүй.

Энд хэтэрхий их өгөөж, өгөөж гэж ярьж байгаад, өгөөжгүй хадгалаад байна гэж ярьж байгаад үүнийг задгай тавьчихдаг. Тэгээд өндөр өгөөж амласан банкууд дээр аваачаад юун өгөөж манатай, алдчихсан маш гашуун түүхтэй. Бид нар.

Тийм учраас сүүлийн 5 жилийн хугацаанд бид дотоодын, эрсдэлд очиж болзошгүй ийм хөрөнгө оруулалтын хөрөнгө мөнгө байршуулах асуудлыг бүрэн зогсоосон байгаа.

Ингээд ерөөсөө Төв банканд дээр байршиж байгаа. Ямар зарчим барих вэ гэхээр одоо энэ татвар төлөгчид төсвийн мөнгөөр бүрдэж байгаа энэ сангуудыг

▷ Нэгдүгээрт, **найдвартай** байх ёстой.

▷ Хоёрдугаарт, **хөрвөх чадвартай** байх ёстой.

Энэ хоёр биелж байвал дараа нь өгөөж хайж болно. Өгөөж хайхгүй ч байж болно. Найдвартай л хадгалагдаж.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Ж.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа.

Энэ Баялгийн сангийн хуулиар энэ АМНАТ-ийн орлогыг чинь 2025 онд 65 хувийг Баялгийн сан төвлөрүүлэх ёстой.

Тэгээд дагаж өргөн барьсан энэ хуульд өөрчлөлт орох гэж байгаа юм шиг байна.

Ж.Ганбат дарга аа, Ж.Ганбат даргаас асууя.

Тэгээд яагаад энэ хуулийг өөрчилж байгаа юм бол? Шалтгаан нь юу юм бол? Юуг нь өөрчилж байгаа юм?

Сая бид сонгуулийн өмнөхөн л Монгол Улс даяар баахан сенсац болгож байж л баталсан.

АМНАТ-ын орлогын 65 хувийг санд төвлөрүүлэх ёстой.

Юуг нь өөрчилж байгаа юм бэ? Яагаад өөрчлөх болов оо?

Би бол өөрчлөлтийг нь мэдэж байна. Тангай таарах нь уу, үгүй юу. Шалгая даа.

Тэр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2022 оны 12 сарын 09-ний өдөр батлагдсан. 2023 оны 12 сарын 31-ний өдөр хэрэгжиж эхэлж байгаа.

Уг нь төсвөө дагаад түншлэлийн зорилт, арга хэмжээг хамтад нь батлах ёстой.

Байнгын хороон дарга аа, ийм хуультай.

Тэгээд ийм санаачилга байхгүй юм уу? Ийм юм ерөөсөө сонсогдохгүй юм.

Хамтад нь хэлэлцэх ёстой гээд байсан. Хамтад нь хэлэлцэж байгаа зүйл байхгүй юм. Би эсвэл хол яваад байна уу? Эсвэл энэ хууль чинь биелэхгүй байгаа юм уу? Хариулт сонсьё.

Б.Заяабал гишүүн, одоо энэ Ж.Батжаргал гишүүн энэ тэрийн хэлээд

байгаа наад юу чинь хэцүү дээ. Одоо тэр хөгжлийн одоо юу билээ энэ чинь одоо Бүсчилсэн хөгжлийн татварын тэр хөнгөлөлт гээд байгаа чинь бол.

Алдартай жишээ байгаа шүү дээ. Одоо энэ Алтанбулагийнхаа чөлөөт бүсийг хараач.

Тэнд ажиллаж байгаа хүмүүс хэлж байна лээ шүү дээ. Монгол Улс чинь ийм их архи хэрэглэдэг юм уу гэж. Дандаа татваргүй архи орж ирж байна шүү дээ. Монгол Улсад. Сангийн яам юу харж байдаг юм? Наад алдартай жишээ чинь байна шүү дээ. Очоод хүмүүс юу юу ярьсан нь хүртэл байна.

Тэгээд гишүүд хоёр, гурван юм хэлэхээр тэрийг ойлгохгүй байна, үүнийг ойлгохгүй байна гээд. Наад чөлөөт бүсээ янзлаач тэгээд.

Монгол Улсын Ерөнхийлөгч хууль батлаад наадах чинь бүр нэлээн томоохон хуультай болчихсон байна шүү дээ.

Тэгээд өдөрт хэдэн зуун машинаар нь, хэдэн зуун хайрцгаар нь. Тэгээд ямар ч татваргүй. Тэгээд зүгээр хараад л байж байдаг. Нэг хэсэг жоохон чангарсан. Одоо тэгээд л хулгайдаа дийлдэгдээд л. Тэгээд хэлсэн хүмүүсийг нь хэвлэлээр нэг хусаж өгөөд л.

**Ц.Даваасүрэн:** Ж.Ганбат хариулах юм байна. 5 номер.

**Ж.Ганбат:** Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс “Ирээдүйн өв сан”-д хуваарилагдах дүнг тогтоож өгөх

байдлаар энэ хуульд өөрчлөлт оруулж өгөхөөр тусгаж байгаа.

2025 онд 40 хувь байхаар ингэж зааж өгсөн байгаа.

Энэ дээр бид зөвхөн хувь хэмжээний хувьд “Баялгийн сан”, “Ирээдүйн өв сан”-д ашигт малтмалын нөөц сангаас “Ирээдүйн өв сан”-д хуваарилах дүн 2024 онд 20.0 хувь байсныг 2025 онд 40.0 хувь гээд нэмэгдүүлж байгаа.

Тэгээд 2026 оноос бид 65.0 хувийг хуваарилна гэж тооцож тусгасан байгаа.

Тэгэхээр 2024 онд 20.0 хувь байгааг 2025 онд 40.0 хувь болгож илүү “Ирээдүйн өв сан”-д нэмж хуваарилах дүнг нэмэгдүүлэх байдлаар ингэж тус тусгасан байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тодруулах уу? Ж.Ганбаатар. Заримыг нь хариулъя. Б.Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Сая манай Ж.Ганбат Төрийн нарийн бичгийн даргын хэлсэн дээр би нэмж хэлье.

Ж.Ганбаатар гишүүн сайд байсан манай Засгийн газрын үед “Ирээдүйн өв сан”-г бид 2022 онд 100 хувь хүүхдийн мөнгөнд зарцуулсан.

Хүүхдийн мөнгөнд тавихад тухайн үед төсвийн алдагдал маш хүнд байсан.

Ингээд тэрнээс хойш шат дараатайгаар буцаагаад **65.0** хувь хүртэл нь үе шаттайгаар нөхөж хийж байгаа гэж ойлгож болно.

- ▶ 2024 онд **20.0** хувь,
- ▶ 2025 онд **40.0** хувь,
- ▶ 2026 онд **65.0** хувь нөхөж орохоор байгаа.

Хавар зарлаж байсан асуудлууд зарцуулалтуудаа зарлаж байсан. Энэ бол одоо “Ирээдүйн өв сан”-гийн хуваарилалт буюу орлого талд нь орж байгаа ийм өөрчлөлт гэж ойлгож болно.

Чөлөөт бүсийн хувьд Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүн байна уу? Эдийн засаг, хөгжлийн яам чөлөөт бүсээ хариуцдаг. Бүх бодлого, асуудлууд нь тэндээ байгаа. Тийм.

**Ц.Даваасүрэн:** Төр, хувийн хэвшлийн жагсаалт гээд хэлсэн шүү дээ. Тэр яасан. Хэн хариулах юм?

Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүн байна уу? Байгаа юм уу? Эдийн засгийн яамнаас хүн дууд. Манайхан.

Ж.Ганбаатар гишүүн тодруулж байя.

**Ж.Ганбаатар:** Тэр архиныхаа татварыг нөхөж олж аваарай. Би сайд байхдаа хүртэл Засгийн газрын хуралдаан дээр хоёр, гурван удаа хэлсэн.

Тэгээд хэлснийх нь дараа нь л над руу дайраад байдаг юм билээ. Хэвлэлээр.

Сангийн яамныхан Ж.Ганбаатар хэлсэн гэж хэлдэг юм уу, яадаг юм.

Тэгээд наад татвараа олж аваач. Хэчнээн тэрбум төгрөг. Бараг их наяд төгрөгийн юу байна шүү дээ. Энэ дээр чинь.

Тэгээд л Монгол Улсын Ерөнхийлөгч хүртэл хууль батлаад өгөхөөр биелүүлэхгүй. Хэн нь хэнтэйгээ оролцоод байдаг юм. Мэдэхгүй байна. Тэгээд тэрийгээ биелүүлээд тэр мөнгөө олж аваач.

Хоёрдугаарт, наад 65.0 хувь гэж хуультайг 40.0 хувь болгож бууруулж байгаа юм биш үү? Ж.Ганбат дарга аа. Үгүй ээ. Би уншихдаа наадах чинь 65.0 хувь гээд хуульдаа заачихсан байгааг та нар 40.0 болгож одоо дагаж байгаа хуулиараа бууруулж байгаа юм биш үү? Үгүй юу?

Би тэрийг шалгана. Тэгээд чуулган дээр асууя. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхдээ хариулчих хариулчих. 20-оос 40 болгож байгаа гэдгийг. Б.Жавхлан.

**Б.Жавхлан:** 2022 онд бид нэг удаа тэглээд. Тийм. Нэг удаа тэглээд энэ “Ирээдүйн өв сан”-д орж ирэх орлогыг хүүхдийн мөнгөнд зарцуулсан байдаг юм. Яг нөгөө КОВИД-ын хүнд үед.

Тэрнээс хойш ингээд шат дараатай нэмээд явж байгаа. 2024 онд 20.0, 2025 онд 40.0, 2026 онд 65.0 болгоно. Тийм.

**Ц.Даваасүрэн:** 6 номер. 65 байхад яагаад та нар 40 болгоод.

**С.Тулга:** Гишүүний асуултад тодруул өгье. С.Тулга. Хэлтсийн дарга Сангийн яамны.

Гишүүний ярьж байгаа зөв. Үндэсний баялгийн сангийн тухай хууль дээр “Ирээдүйн өв сан”-гийн орлого дээр АМНАТ-ын 65.0 хувь гэж байгаа.

Тэгэхдээ “Үндэсний баялгийн сан”-г дагаж мөрдөх журмын тухай хууль Үндэсний баялгийн сангийн хуульд батлагдахад дагаж гарсан.

Тэр хууль дээр 2024 онд 20.0 хувийг төвлөрүүлнэ гэж байгаа.

Тэгээд 2025 онд энэ 20.0 хувийг 40.0 хувь болгож нэмэгдүүлж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Хуулийнхаа хэмжээндээ хүрээгүй л байгаа юм байна шүү дээ. Тийм ээ. Хүрээгүй байгаа юм байна. Тийм байна.

Тэгэхээр Ж.Ганбаатар гишүүний зөв байна шүү.

Б.Энхбаяр гишүүн асуултаа асууя.

**Б.Энхбаяр:** Би 2025 оны төсвийн хуулийн төслийг дагалдуулж Засгийн газраас өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзэж байгаа.

Монгол Улсын үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1-д Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.

7.Төрийн санхүү, зээл, албан татвар гэсэн ийм Үндсэн хуулийн заалт байгаа юм.

“Бүрэн эрх”, “онцгой бүрэн эрх” гэдэг ойлголт бол ялгаатай ойлголт байдаг.

Үндсэн хуульд заасан “онцгой бүрэн эрх” гэдэг нь юу гэсэн үг вэ гэхээр

хэнтэй ч хуваалцдаггүй буюу бусдад шилжүүлдэггүй зөвхөн Улсын Их Хурал өөрөө эдлэх энэ бүрэн эрхийг онцгой бүрэн эрх гэдэг.

Тэгвэл Төсвийн хуулийг дагалдуулж оруулж ирсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд 22.5.22-т албан татвар төлөгчийн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилээс 90 хувиар чөлөөлөхөөр өөрчлөлт орж ирж байгаа.

Энэ төслийн 3 буюу 22.14-д саяын ярьсан жагсаалтыг буюу

- ямар үйл ажиллагаа
- ямар төсөлд
- ямар хувиар

“татварын хөнгөлөлт үзүүлэх жагсаалтыг Засгийн газар батална” гэдэг заалт байгаа.

Энэ бол үндсэндээ Сангийн сайдын эрхлэх асуудалд байгаа.

Энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн ямар төслийн, ямар орлогыг чөлөөлөх гээд байгаа юм бэ гэдэг нь Улсын Их Хуралд энэ саяын зааснаар ойлгогдохгүй байгаа. Тодорхойгүй байгаа.

Тэгэхээр Засгийн газар Улсын Их Хурлаас татвар чөлөөлдөг онцгой бүрэн эрхийг нь маш ерөнхий заалт тавьж байгаад шууд булааж авах гэж байна.

Үүнийг би хуулийн хулгай гэж хэлээд байгаа юм.

Тийм учраас энэ бол Үндсэн хууль зөрчиж байна.

Засгийн газар Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн зөвхөн өөрөө эдэлдэг энэ эрхийг харанхуй, ерөнхий, тодорхойгүй, тоо байхгүй ийм байдлаар авч болохгүй. Энэ бол авлига болно.

Ямар төсөлд 90 хувийн хөнгөлөлт үзүүлэхийг Засгийн газрын нэг сайд.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Хариулья. Нөгөө бүсчилсэн хөгжлийн юунд. Тэр хэтэрхий ерөнхий байгаа шүү. Тэр үнэн шүү. Хариулья. 4 номер.

**Б.Тэлмүүн:** Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн.

Б.Энхбаяр гишүүний асуултад хариулья.

Татварын ерөнхий хууль болон татварын 30 гаруй хууль байгаа. Энэ дээр нэгдүгээрт Улсын Их Хурал хуулиар эрх олгосон хүрээнд

- *татварын хувь хэмжээг тогтоох, чөлөөлөгдөх барааг кодлох, тодорхойлох, уялдуулсан системийн ангиллын батлах,*
- *татварт ногдох барааны ангилал, тэдгээрт тавигдах шаардлагыг батлах,*
- *хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах төслийн нэрийг батлах*

гэсэн маш олон зүйл, заалтууд 1992 оноос хойш хэрэгжиж эхэлсэн.

Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурал татварын хуулиар Засгийн газарт бүрэн эрхээ шилжүүлэн олгож ингэж яаж байна.

Үүнтэй холбоотойгоор 8 сард батлагдсан хууль дээр үйлдвэр, технологийн паркийн гаалийн татварын хөнгөлөлт, хойшлуулалтыг эдлэх төслийн жагсаалтыг Засгийн газар батлах, эрчим хүчний төслүүдийг гэх мэтчилэн олон жишгүүд байдаг.

Тэгэхээр энэ бол өөрөө Татварын хуулиар Улсын Их Хурал өөрөө бүрэн эрхээ шилжүүлэн олгож байгаа тодорхой хүрээ хязгаарын хүрээнд.

Тэгэхээр энэ дээр бол Үндсэн хуулийн зөрчил үүсэхгүй гэж үзэж байна. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Ер нь шилжүүлсээр байгаад бараг дуусаж байгаа даа.

Одоо ер нь бидэнд юм үлдэж байна уу, үгүй юу? Б.Энхбаяр гишүүн. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Татварыг тогтоох бүрэн эрх бол ер нь Улсын Их Хурлаас гараад явчихсан л даа.

Татварын маргааны зөвлөл гээд Сангийн сайдын байгуулж байгаа энэ байгууллага чинь зөвхөн “Петрочайна” дээр 300 тэрбум төгрөгийн татварыг авах уу, авахгүй юу гэдэг шийдвэр гаргаад байгаа шүү дээ.

Зүгээр тэнд хэдхэн хүн сууж байгаад л.

Тэгээд би энэ асуудлыг өнгөрсөн парламентын үед ярьж байсан.

Тэгээд үүний цаана авлига яригддаг, хянагддаггүй, татвар ногдуулалт дээрээ хуулийн хяналтын байгууллагыг оруулдаггүй. Лобби хийж байгаад прокурор татвар хүчингүй болгосон татварын байцаагчийн шийдвэрийг хянах тэр заалтыг өмнө нь Сангийн яам, татварынхны лоббигоор аваад хаячихсан байсан шүү дээ.

Одоо энэ Улсын Их Хурлаас “татвар чөлөөлдөг” энэ эрхийг нь авахаа больё. Одоо болно.

**Ц.Даваасүрэн:** Санал байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүд.

Б.Жавхлан гишүүн.

**Б.Жавхлан:** Гишүүний саяын хэлсэн зүйл дээр бас нэг юм хэлэхгүй бол болохгүй. Энэ бас буруу ойлголт үлдчих байх.

Татварын ерөнхий газар маргаантай асуудлууд дээр Сангийн яамтайгаа хамтраад олон шүүх дээр оролцдог.

Сая “Петрочайна”-тай холбоотой асуудал дээр шүүх болгон дээр яллаад явж байгаа шүү.

Өөрөөр хэлбэл татварын байцаагч нарын тавьсан актаа хамгаалаад, оролцоод бүгд дээр нь ялсан. Сая хэдхэн хоногийн өмнө хүртэл нэг шүүх дээр орсон. Ялсан. Тийм ээ.

Байнга яллаад явж байгаа. Энэ татварын маргаантай, акттай ямар ч асуудал дээр Засгийн газар огт ялагдаагүй байгаа.

Б.Заяабал даргын үед ч ганц ч ялагдаагүй, одоо ч ер нь ганц ч ялагдаагүй ингээд явж байгаа. Бүгд дээр нь ялаад явж байгаа шүү. Актууд дээрээ. Тэрийг бас хамаагүй ингэж болохгүй. Энэ чинь хэдэн мянган хүн оролцоод энэ чинь нэг том салбар, институцийн ажлыг ингэж шууд дүгнэж бас болохгүй байх шүү.

**Ц.Даваасүрэн:** Одоо та хэд Оюу Толгойтой хийж байгаа маргаанаа үргэлжлүүл ээ. Тэр зогсчихсон байгаа юм билээ.

Тэгвэл одоо яг итгэл үнэмшилтэй болно шүү.

**Б.Жавхлан:** Наадах чинь зогсоогүй шүү дээ.

**Ц.Даваасүрэн:** Түр зогсчихсон байгаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дагаж өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, тогтоолтой холбогдож асуулт асууж дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Б.Энхбаяр байгаа юм уу? Б.Энхбаяр гишүүн үг хэлье. Б.Түвшин гишүүн. Хоёр гишүүн байгаа юм байна.

Б.Энхбаяр, Б.Түвшин гишүүн. Алх цохисны дараа л боллоо. Одоо яах вэ. Тэнд гараад ирвэл би хэлье. Д.Пүрэвдаваа гишүүн. Тэгвэл.

Ингээд харагдахгүй болохоор хэн нь эхлэх гээд байгаа нь мэдэгдэхгүй болчихоод байх юм. Д.Пүрэвдаваа гишүүн эхлэх юм байна. Чиний микрофоныг өгчхөж.

**Д.Пүрэвдаваа:** Энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ дагаж орж ирсэн хуулийн төсөл дээр ялангуяа энэ хөнгөлөлт эдлүүлж байгаа, татварын хөнгөлөлт. Мөн гаалийн хуульд өөрчлөлт оруулж 100 хувийн хөнгөлөлт эдлүүлнэ гэсэн энэ жагсаалтуудын тал дээр илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгмөөр байна.

Жишээгээр энэ дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй гэдгээ яаж тодорхойлж байгаа юм. Тэгээд тэр хүчин зүйлүүд нь уг нь илүү тодорхой байвал аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа төлөвлөхөд нь нэмэр болох юм уу. Аягүй бүрхэг, тодорхойгүй орж ирж байна гэж харж байна.

Мөн саяын гаалийн 5 жил, 90 хувиар хөнгөлөлт эдэлнэ.

Хөнгөлөлт эдлүүлснээрээ ямар кластер дэмжигдэх гээд байгаа юм, ямар үр дүнд хүрэх гээд байгаа гэдгээ аягүй тодорхой нийгэмд болон Улсын Их Хурлын гишүүдэд мэдээллийг дэлгэрэнгүй өгмөөр байна гэдэг ийм саналтай байна.

**Ц.Даваасүрэн:** Б.Түвшин гишүүн.

**Б.Түвшин:** Одоогоор Үндэсний баялгийн сангийн хүү гэдэг юм уу, өгөөж 55 тэрбум төгрөг ямар нэгэн байдлаар бүртгэгдэх шийдлээ олоогүй байгаа.

Ер нь цаашдаа Баялгийн сангийн 6 орчим их наяд төгрөгийг өгөөжтэйгөөр байршуулах ёстой. Мэдээж найдвартай, хөрвөх чадвартай байх ёстой. Тэгэхдээ үүний төлөө мэргэжлийн Сангийн яам байдаг гэж ойлгодог.

Тийм учраас ирээдүйд орж ирэх валютаар байршиж, тэр хэмжээгээрээ тэр өгөөжөө өгч байх ёстой гэдэг дээр бас хэлье.

Хоёрдугаарт, Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн ялангуяа төрөөс хариуцаж байгаа хэсгийг нь тусад нь харуулдаг болохгүй бол нийт сан өөрөө алдагдалтай юм шиг. Тэр алдагдлыг төрөөс нөхөж байгаа юм шиг харагдаад байгаа юм.

Гэтэл төрөөс гаргасан шийдвэрээ л өөрөө санхүүжүүлж байгаа.

Гуравдугаарт, Эрүүл мэндийн даатгалаар санхүүжиж байгаа зайлшгүй эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг төр хариуцах үүрэгтэй. Татвар төлөгчийн мөнгөөр төсвөөс хариуцах үүрэгтэй.

Эрүүл мэндийн даатгал өөрөө эрсдэлд суурилсан тодорхой хэмжээний шууд зардлуудыг л хариуцдаг болгох хэрэгтэй.

Тийм учраас Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангуудын бие даасан тусгайлсан шинэчлэлийн хөтөлбөрийг зайлшгүй явуулах шаардлагатай байна гэдгийг хэлье.

**Ц.Даваасүрэн:** Б.Энхбаяр гишүүн үг хэлье.

**Б.Энхбаяр:** Бид ер нь Улсын Их Хурал буюу Монголын ард түмний төлөөллийн байгууллага Үндсэн хуульд заасан ард түмнийг төлөөлөх тэр суудал дээрээ бат зогсмоор байна.

Миний санаж байгаагаар КОВИД-ын үед одоо манай Ц.Даваасүрэн дарга бол үүнийг их ярьдаг байсан.



Энэ Улсын Их Хурал чинь Улсын Их Хурал биш болчихлоо шүү. Бүх Улсын Их Хурлын шийддэг асуудал Засгийн газар луу шилжлээ.

Бид КОВИД-ын үеийн хууль баталсан.

Улсын Их Хурлын баталсан төсвийг Засгийн газар, Сангийн сайд төсөв хооронд захиран зарцуулах онцгой бүрэн эрхийг 2 жилийн хугацаанд хэрэгжүүлж явсан.

Хэрэг дээрээ Улсын Их Хурал энэ хугацаанд ард түмнээс олгосон Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхээ бид КОВИД-ын гэх онцгой нөхцөл байдалд шилжүүлсэн.

Миний хувьд тухайн үед энэ Үндсэн хууль зөрчиж байгаа гэдэг байр суурийг илэрхийлдэг байсан. Цөөнх болж байсан.

Одоо КОВИД дуусаад 2 жил болчихлоо. Засгийн газар маань дасчхаад байна.

Улсын Их Хурлын хяналтаас гарсан тэр 2 жил нь өөрөө Засгийн газрын хувьд дадал болж хувирсан байна.

Энэ нь өөрөө хулгай хийх боломжийг, авлигад өртөх боломжийг улам гааруулж байна. Одоо эндээ зогсооё.

► Засгийн газар маань ердийн горимоор ажиллаж сурмаар байна.

► Улсын Их Хурал маань ердийн горимоор ажилд сурмаар байна.

Энэ татвар чөлөөлдөг онцгой бүрэн эрхийг Улсын Их Хурлын бүрэн

эрх байна гээд 1992 онд Үндсэн хууль баталчхаад байхад ердийн хуулиудаар дамжиж хулгайлаад байна.

Тэгээд одоо хэний, ямар компанийн, хэдэн тэрбумын юм уу, их наядын татвар чөлөөлөх үү, үгүй юу гэдгийг тэнд Сангийн сайд юм уу, Татварын дарга юм уу, Б.Тэлмүүн дарга шийдээд байж болохгүй. Энэ авлига болно.

500 тэрбумын татварыг чинь 90 хувь чөлөөлчихье. Чи хэдэн хувь өг гэж нэхэх гэж байгаа юм.

Энэ Улсын Их Хурал дээр яагаад онцгой бүрэн эрхэд үүнийг шийдэв гэхээр үүнийг хяналттай, ард түмний хяналтад, энэ цаанаа хэдэн их наяд, тэрбумын татвар чөлөөлөх бид эрх олгох гээд байгаа юм бэ. Ер нь.

Яг ямар бараан дээр олгох гээд байгаа юм.

Энэ Гаалийн албан татварын хууль чинь бас яг тийм байгаа байхгүй юу. Боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж дээр 100 хувь чөлөөлнө.

► Ямар үйлдвэрлэл дээр яриад байгаа юм,

► Ямар хугацаанд яриад байгаа юм,

► Хэдэн төгрөгийн татварыг бид хөнгөлөх гээд байгаа юм.

Ямар ч мэдээлэл байхгүй.

Тэгээд ийм том эрх өгөх гээд байгаа байхгүй юу. Ганц ганц заалтуудаар.



Тийм учраас би төсөв дагасан хуулиудыг дандаа үздэг юм.

Төсөв дагасан хуулийн хулгай хийгээгүй зүйл ерөөсөө байхгүй. Дандаа орж ирдэг.

Сая ээлжит бус чуулганы үеэр бас шүгэл үлээсэн шүү дээ. Тендерийн хуулиар хулгай хийх гээд байна гээд.

Тэгээд Улсын Их Хурлаас буцаасан. Сарын өмнө хэлээд байхад дахиад л оруулаад ирж байгаа байхгүй юу.

Одоо наадах хулгайч зангаа тат. Одоо болно.

Улсын Их Хурал хариулт өгмөөр байна. Энэ дээр. Ц.Даваасүрэн дарга аа.

Одоо болно оо гэдэг хариултыг нь Төсвийн байнгын хороо өгмөөр байна.

Би энэ Төсвийн байнгын хороонд байдаггүй байхгүй юу. Тэгээд зориуд орж ирж үг хэлээд байгаа юм.

Яагаад гэхээр шинэ дэгээр чуулган дээр үг хэлэх бололцоо байхгүй. Ганцхан Төсвийн байнгын хороон дээр л үг хэлэх бололцоо олдож байгаа 3 минутыг ашиглаж би энэ байр сууриа хэлнэ.

Тэгэхээр энэ хуулийг буцааж өгөөч ээ гэж би Төсвийн байнгын хорооны гишүүдээс хүсэж байна. Одоо шууд.

**Ц.Даваасүрэн:** Болохгүй шүү дээ. Ж.Баярмаа гишүүн үг хэлнэ.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Хэлэх гэж байсан үгийг сая Б.Энхбаяр гишүүн бүр яг 100 хувь хэлчихлээ.

Тэр Үндсэн хуулийн Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдаж байгаа. 25.1.7-д байгаа. Тийм ээ.

“Албан татварын бодлогыг Улсын Их Хурал тогтооно.” гэсэн. Энд халдаж байгаа.

Цаашилбал, Татварын ерөнхий хуулийн дагуу татварын үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг бас зөрчиж байна.

Жишээлбэл,

- ▶ татвар бий болгох,
- ▶ тогтоох,
- ▶ ногдуулах,
- ▶ тайлагнах

энэ бүх процесс нь “зайлшгүй байх” гэж байгаа юм.

Тэр зайлшгүй байх үндэслэл ерөөсөө харагдахгүй байна.

“Тодорхой байх” гэж байгаа юм. Сая бүгд ярьсан. Тийм ээ. Жагсаалт нь юу, хэн оруулах гээд, ямар компани орох юм тодорхойгүй байна.

Үүний цаана чинь нөгөө ялгаварлал явагдана.

Ямар компанид нь олгох гээд, ямрыг нь үлдээх гээд байгаа юм.

Энэ дээр чинь нөгөө Аж ахуйн нэгжүүдээ ялгаварладаг асуудал үүсэхээр энэ чинь нөгөө “шударга байх” гэдэг зарчмыг бас хааж байгаа.

“Үр ашигтай байх” гэдэг дээр бас мэдэхгүй. Ямар тооцоолол хийгээд энэ үр ашигтай байх юм гэж тооцсоныг мэдэхгүй байна.

Тэгэхээр “тодорхойгүй” гэдэг нь гол хүчин зүйл болж байна л даа. Яагаад гэвэл өнөөдрийг хүртэл импортыг орлоод, экспортод бүтээгдэхүүн гаргаж байгаа, үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг яах гэж байгаа юм бол гэдэг асуулт байна.

Яах вэ, ер нь асуудал байна. Тийм ээ. Цоо шинээр энэ чиглэлийн бизнес хийх гэж байгаа аж ахуйн нэгжүүдэд хамааралтай юм болов уу гэдэг асуулт байна.

Хэрвээ тийм гэвэл өмнөхүүдээ яагаад ялгаварлах юм гэдэг асуудал байна.

Гээд ингээд бүх талаараа л яг сая Б.Энхбаяр гишүүн бүгдийг нь хэлчихлээ л дээ.

Тэгээд энэ салбарын хуулиудаар ингэж төсвийг хүчинддэг асуудлыг болимоор байгаа юм.

Зөвхөн энэ удаад биш. Зүгээр ороод л дөнгөж шинэ гишүүн зах зухаас нь яагаад үүнийг төсөвт суулгаад байгаа юм бэ гэхээр “өө., тэр салбарын тийм хуульд тэгээд оруулчихсан юм” гээд нэг ийм хариулт өгдөг.

Одоо тэр “соёлын ваучер”-ын зардлыг яагаад оруулж байгаа юм бэ гэхээр Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хуульдаа “үнэгүй тараана” гээд биччихсэн юм. Тэгээд тэр хуулиа хэрэгжүүлэхийн тулд төсөвт 18.3 тэрбум оруулж ирж байгаа юм гэх мэтчилэн.

Ингээд бусад хуулиудаар татвар нэмэх, хөнгөлөх, халамж тараах, орон тоо нэмэх, хасах гэдэг зүйлүүдийг тусгачхаад.

Тэгээд яг тэр хуулиа бариад төсөв хэлэлцэх болохоор

- *ийм хуультай юм,*
- *ингэж хөнгөлөх юм,*
- *ингэж тараах юм*

гээд байдаг энэ асуудлыг одоо ёстой яг таслан зогсоох ёстой юм байна гэдэг ийм бодол төрөөд байгаа юм.

Тийм учраас би зарчмын зөрүүтэй санал гээд уг нь оруулчихсан байгаа.

Энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татварт оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэхгүй байгаач ээ. Бүр хэлэлцэх эсэхээс хасаач ээ гэдэг ийм саналыг бас оруулж байгаа юм.

Би бас байдаггүй. Энэ Байнгын хороонд. Тэгэхдээ бас зориуд орж ирж хэлж байгаа юм.

Тэгэхээр Байнгын хорооны гишүүд энэ зүйлийг дэмжээд “хэлэлцэхгүй байх нь зүйтэй” гэдэг саналыг минь дэмжээрэй гэж хүсэж байна.

**Ц.Даваасүрэн:** Гишүүд хуулийн төслүүдтэй холбогдуулаад асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо хууль нэг бүрээр дэмжих эсэхээр санал хураалт явуулна.

Эхлээд нэг туршилтын санал хураалт явуулчихъя даа. Хэдүүлээ. Туршилтын санал хураалт. Ирцийн.

1. Үндэсний байгалийн сангийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёололоор санал хураалт явуулъя. /алх цохив/

17 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 58.8 хувийн саналаар хэлэлцэхийг дэмжсэн байна.

2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

17 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжиж, 23.3 хувийн саналаар энэ хуулийн төсөл дэмжигдээгүй байна.

3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

17 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 47.1 хувь буюу энэ төсөл хэлэлцэх нь дэмжигдээгүй байна.

4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Тийм. Б.Энхбаяр чинь санал өгөхгүй байхгүй юу. Манай хорооны гишүүн биш.

17 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж, 52.9 хувийн саналаар энэ хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ.

5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

17 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжсэн санал өгч энэ хууль 41.2 хувь байгаа тул хэлэлцэх нь дэмжигдсэнгүй.

Гишүүд ээ, зарим нэг хуулиудын хэлэлцүүлэгийг нь явцын дунд хэдүүлээ янзлаад явъя л даа.

6. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Гишүүний микрофоныг өгье. 3. Мэндсайхан гишүүний микрофоныг өгье.

**3. Мэндсайхан:** Сая татварын асуудал дээр миний энэ юу ажилласангүй шүү дээ.

**Ц. Даваасүрэн:** Нөгөө Үнэт цаасан дээр үү?

**3. Мэндсайхан:** Үнэт цаасан дээр.

Тэгэхээр дахин санал хурааж өгөөч ээ гэдэг хүсэлтэй байна.

**Ц.Даваасүрэн:** З.Мэндсайхан гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүйд тооцох тухай санал хураалт явуулъя. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй саналыг 17-гоос 9 гишүүн дэмжиж, дэмжигдсэн байна.

Зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэн тул “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

17-гоос 8 гишүүн дэмжиж. Дахиад ажиллаагүй юу. Зарим гишүүдээ дуудъя.

Б.Жавхлан гишүүний микрофон өгчих.

Төсвийнхөө алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэргүй байж болохгүй ээ. Нөхөд өө.

**Б.Жавхлан:** Татвар тал дээр одоо яг Сангийн яам татвар орлого бүрдүүлэх талаасаа хөнгөлөлт, чөлөөлөлт болгоныг дэмжээд байдаг зүйл ерөөсөө байхгүй шүү дээ.

Аль болох чөлөөлөхгүй л байх тал дээрээ хатуу байдаг. Ялангуяа НӨАТ гээд гол татварын орлого бүрдүүлдэг ийм хүчтэй татварууд дээрээ.

Энэ чинь өөрөө энэ бүсчилсэн хөгжлийн суурь үзэл баримтлал. Тэгээд бүсчилсэн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбар, энэ юмнуудыгаа гишүүд өөрсдөө оролцоод бүс бүс дээрээ тэргүүлэх чиглэлээ тодорхойлоод.

Тэгээд тэр дагуу явж байгаа ялгавартай, тэр хөгжлийг л дэмжиж байгаа л татварын бодлого шүү дээ.

Тэгээд тэрийг цөөн хэдэн хүмүүсийн попролтод автаад тушаа хаячихаар одоо тэгээд цаашаа бүсчилж хөгжих ямар бидэнд бодлогын хэрэгсэл байх юм бэ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, түрүүн би өмнөх Байнгын хороон дээр байж байгаад хоцроод ороод ирсэн. Уучлаарай.

Засгийн газрын зээллэг, бонд дээр чинь энэ байгаа дүн дотор 1.4 чинь нийслэлийн бонд шүү дээ.

Засгийн газар энэ дээр чинь төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх нэг төгрөгийн ч бонд гаргахгүй.

Улсын Их Хурлаас дунд хугацааны 3 жилийн бид нарт даалгавар өгчихсөн. Тэр хүрээнд л явж байгаа.

Дотоод бондыг бид жил болгон л зөвшөөрөл авдаг. Гаргах эсэхийг тухайн үедээ шийдээд явдаг. Одоогоор 5 жилийн хугацаанд нэг төгрөгийн ч дотоодын бонд гаргаагүй явж байгаа ийм л дүн шүү дээ.

Тэгээд юунд зориулж ямар бонд гаргаж ирэх юм тэр шийдвэр нь Их Хурлаар дахиад орж ирнэ. Тэгээд ийм л зүйлүүд байгаа юм.

Уг нь хэлэлцэх эсэхээ дэмжээд тэгээд тэр томьёолол дээрээ ажлын хэсэг дээрээ бас яриад л явчихвал болохгүй юм байхгүй шүү дээ.

**Ц.Даваасүрэн:** Татварын асуудал дээр хэдүүлээ эргээд сайн ярьцгаая.

Засгийн газрын бондыг нь дэмжсэн нь дээрээ. Гишүүд ээ.

Төсвийнхөө алдагдлыг санхүүжүүлж байгаа эх үүсвэр юм чинь.

З.Мэндсайхан гишүүнийх болохгүй байгаа юм байна. Тийм ээ.

Дахиад З.Мэндсайхан гишүүн санал гаргая.

**З.Мэндсайхан:** Үгүй үгүй. Сая сүүлийн бондын.

Миний энэ хурууны юу чинь ажиллахгүй байна. Санал хураалт дээр. Уг нь дэмжиж өгөөд байх юм.

**Ц.Даваасүрэн:** Одоо дахин дахин хураагаад баймааргүй байна. Тэр юуг нь анхаараадхаач.

**З.Мэндсайхан:** Би эндээс гарч байгаад тэнд очоод суучих уу? Ажилладаг юман дээр суух юм уу.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл тэг. Ажилладаг юман дээр суучих. Ажилладаг микрофон дээр суучхаж болж байна.

Ингээд хураая. Миний энэ хажуу дахь дээр суучих. Бүртгүүлчихсэн үү.

**З.Мэндсайхан:** Бүртгүүлчихлээ.

**Ц.Даваасүрэн:** З.Мэндсайхан гишүүний микрофоныг өгье.

Саналаа гаргачихсан билүү. Тэгвэл З.Мэндсайхан гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. /алх цохив/

Дуудаач дээ. Тэгээд Гадаад харилцааны сайд юу гэж Төсвийн байнгын хороонд орсон юм. Тэгээд л дандаа гадаад уулзалт гээд л явчих юм. Сайд нараа оруул.

Зарлагын хяналтын дэд хорооны дарга гээд дуудчих.

Санал хураалтаа явуулъя. Одоо хэн горимын санал гаргах вэ. Би гаргах уу? Би гаргачихъя.

Саяын 6 дахь санал дээр гишүүдийн төхөөрөмж алдаатай ажилласан учраас 6 дахь саналыг хүчингүй болгоё гэдэг санал хураалт дахиад явуулъя. /алх цохив/

Гишүүд ээ, анхаараарай.

Дахиад зарлана. Ажлын хэсгийг бол больё. Танайх хуралдаж болно шүү дээ. Ажлын хэсгийг өнөөдөр больчихлоо. Зарлагын хяналт хуралдана шүү.

Хурлыг жич зарлая.

## ЗАВСАРЛАГА

**Ц.Даваасүрэн:** Дуудчихъя. Тэгээд хуралдаанаа үргэлжлүүлье. Хэдүүлээ.

Маргаашийн хэлэлцэх асуудал чинь ерөөсөө ганцхан манай энэ асуудал юм билээ шүү дээ. Чуулган.

Хэрвээ энэ асуудлаа бид амжуулахгүй бол маргааш чуулгангүй болчихоод байгаа юм байна.

Хуралдаанаа үргэлжлүүлье. Гишүүд ээ.

Түрүүн санал хураалт 6 дахь санал дээр явж байсан.

Б.Батцэцэг гишүүн горимын санал гаргая гэж байсан. Б.Батцэцэг гишүүн горимын саналаа гаргая.

**Б.Батцэцэг:** 6 дахь асуудал дээр миний микрофон ажилласангүй.

**Ц.Даваасүрэн:** Кноп уу?

**Б.Батцэцэг:** Төхөөрөмж ажилласангүй. Микрофон биш ээ. Төхөөрөмж ажилласангүй. Уучлаарай.

Дахин санал хураалт явуулж өгнө үү. Дарга аа.

**Ц.Даваасүрэн:** Б.Батцэцэг гишүүний гаргасан горимын саналын дагуу 6 дугаар асуудлыг санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя.

Гишүүд ээ. Анхааралтай байгаарай. 6 дахь санал хураалтыг хүчингүй болгоё. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 61.5 хувийн саналаар дахин санал хураалт явуулахад дэмжигдсэн байна.

Ингээд 6 дахь саналыг. Гишүүд ээ, анхааралтай байгаарай. 6 дахь саналыг дахин хураая.

“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэдэг саналыг дахин хураая. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 84.6 хувийн саналаар 6 дахь санал дэмжигдлээ.

7 дахь санал. “Засгийн газар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8 дахь санал. “Тогтоолын төслийн хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 84.6 хувиар 7 дахь санал дэмжигдсэн байна.

Б.Жавхлан гишүүн нэг горимын санал хэлье гээд байсан уу, үгүй юу? Б.Жавхлан гишүүний микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Баярлалаа.  
**Ц.Даваасүрэн** дарга аа.

Тэгээд өнөөдөр чинь одоо таван Байнгын хороогоор дамжиж гүйсээр байгаад Төсвийн байнгын хорооны өмнөхөн бас нэг өөр Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гарч ирээд.

205 тэрбум төгрөгийн нэг удаагийн зарчмын зөрүүтэй санал гарч ирээд.

Тэгээд тэнд байхгүй бол болдоггүй. Тэгсээр байгаад жоохон хоцорчихсон шүү. Уучлаарай.

Тэр хойгуур тэр 2 татварын асуудал явчихсан. Түүн дээр гишүүддээ зүгээр нэмэлт хоёрхон тайлбар хэлэх гэсэн юм.

Нэг нь, аягүй чухал шүү. Маш олон жил ярьсан. Одоо хүн болгон ярьдаг, үйлдвэрлэгч нар ярьдаг, дотоодын баялаг бүтээгчид ярьдаг, хувийн секторынхон яг хүлээж байгаа нэг зүйл байгаа.

Тэр нь юу вэ гэхээр салбар харгалзахгүй. Боловсруулах шатаа ахиулж байгаа технологийн тоног төхөөрөмжүүдийн гаалийн албан татварыг бүрэн чөлөөлж байгаа.

Өмнө нь сугалаад сугалаад, салбар салбараар нь ингээд нэг тэргүүлэх чиглэл гээд л, хөнгөн аж үйлдвэрийн ч гэдэг юм уу, ингээд явчихдаг байсан. Одоо бол ингээд салбар харгалзахгүйгээр оруулаад ирж байгаа ийм юм байгаа юм.

Тэгэхээр тэрийг дэмжээд явчихвал одоо энэ Их Хурлын маань уг нь хамгийн эхний татварын бодлогоор дэмжиж гаргаж байгаа юман дээр олон нийтээс 100 хувь дэмжлэг авах ганц юм нь энэ байгаа байхгүй юу. Уг нь бол.

Үүнийг та хэд маань ойлгоно байх аа гэж, дэмжинэ байх аа гэж найдаж байна.

Нөгөөдөх нь бүсчилсэн хөгжлийн татвар дээр, ялгаатай татвар дээр шинэ юм энэ дээр эмзэг байгаа бол тэр батлахыг нь, жагсаалт энэ тэрийг нь Засгийн газар Их Хурал руу ороод Их Хурал дээр баталдаг болгочих л доо. Эсвэл.

Тэгэхгүй бүсчилсэн хөгжлийн ялгаатай, нөгөө бүс бүрээр нь тэргүүлэх чиглэл гээд хоорондоо кластерлана гээд бид нарын зөндөө ярьсан суурь бодлогууд маань татвараар явах ганц хөшүүрэг нь ингээд байхгүй болчих гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг дахиж эргэж хараад Их Хурал дээр тэгвэл тэрийг нь баталдаг, жагсаалтыг нь хийдэг тийм болгоод өгөөч ээ л гэж Засгийн газраасаа хүсэх байна. Тэгээд ийм хоёрхон товчхон.

**Ц.Даваасүрэн:** Гишүүдийн яриад байгаагаар хэдүүлээ тодорхой болгох асуудлыг нь тодорхой болгоод, тэгээд жагсаалтыг Их Хурал баталдаг болоод ингээд өөрчлөөд явах боломж байгаа учраас.

Яах вэ, хэдүүлээ чуулган дээр хэлэлцэх эсэхээ дэмжихээд тэгээд харин Их Хурлын бүрэн эрхтэй холбоотой асуудлаа яриад Их Хурал руугаа шилжүүлэх юмнуудаа шилжүүлээд, тодорхой болгох юмнуудыг нь бүр тодорхой болгож.

Бүсэд ямар ямар чиглэлийн, жишээлбэл баруун бүсэд аль аль чиглэлийнхийг нь яах вэ гэсэн байдлаар



байдаг юм уу, ярилцаад тэгээд өөрчлөөд явахад би болчих байх гэж бодоод байгаа юм.

Ялангуяа “боловсруулах үйлдвэрлэлийн технологи” оруулж байгааг дэмжих нь зүйтэй л дээ.

Тэгээд яах вэ тэрийгээ хэдүүлээ тодотгоод явъя.

Ингээд санал хураалт явуулж дууслаа. унасан саналуудаа хэдүүлээ эргээд яая чуулганы нэгдсэн хуралдаанд

танилцуулахыг Ж.Батжаргал гишүүн танилцуулчихъя юу Ж.Батжаргал гишүүн танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн дээрх хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтын хүрээнд хэлэлцэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаан үүгээр дуусаж байгааг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ.

Хуралдаан 1 цаг 57 минут үргэлжилж, 17 цаг 57 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**